

**БУЛГАН АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Гүйцэтгэсэн хугацаа: 2020 оны 10 сарын 20-ноос 2021 оны 1 сарын 25

Тайлан боловсруулсан: Х.Нарангэрэл, захирал Гэрэлт ирээдүй оршихуй ТББ
Н.Баянжаргал, зохицуулагч Гэрэлт ирээдүй оршихуй ТББ
Батзориг, сургагч багш Гэрэлт ирээдүй оршихуй ТББ
С.Батхуяг, гишүүн ХБИ Оргил Мээж хоршоо
П.Хишигдаваа, гишүүн Ажил олгогч эздийн холбоо
М.Батчимэг АЗДТГ Нийгмийн бодлогын мэргэжилтэн

2021 он

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт

Хүснэгтийн жагсаалт

Зургийн жагсаалт

Талархал

ОХШҮ-ний хураангуй

Нэг. Удиртгал

1.1 Үндэслэл

1.2 Зорилго зорилтууд

1.3 ОХШҮ-ний хамрах хүрээ

Хоёр. ОХШҮ-ний арга зүй

2.1 Мэдээлэл цуглуулах арга зүй

2.2 Түүвэрлэлт

2.3 Мэдээлэл цуглуулалтын үйл ажиллагаа

2.4 Зөвлөлдөх уулзалтууд

Гурав. Оролцооны Хяналт Шинжилгээ Үнэлгээний үр дүн

3.1 Оролцооны хяналт шинжилгээний үр дүн

3.1.1 ОНЖДХ-ийн төлөвлөлт ба хэрэгжилт

3.2 Оролцооны үнэлгээний үр дүн

3.2.1 ОНЖДХ болон жендэрийн талаар олон нийт болон оролцогч талуудын мэдлэг, ойлголт

3.2.2 ОНЖДХөтөлбөрийн хэрэгжилтийн байдал

3.2.3 ОНЖДХ-ийн үр шим хүртэгчид

3.2.4 ОНЖДХ цаашид хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага

4. Дүгнэлт

5. Бодлогын зөвлөмж

6. Ашигласан материал

7. Хавсралт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
БЯ	Бүлгийн ярилцлага
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГЯ	Ганцаарчилсан ярилцлага
ДЗМОУБ	Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллага
ЖЭТБ .	Жендэрийн эрх тэгш байдал
ЖЭТБХДХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ .	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
НБ	Нийгмийн бодлого
ОН	Орон нутаг
ОНЖДХ	Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр
ОХШҮ	Оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ
ОҮ	Оролцооны үнэлгээ
ТАХ	Төрийн албан хаагч
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын их хурал
ЦГ	Цагдаагийн газар
ХНХЯ	Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яам
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

ХШҮ	Хяналт шинжилгээ үнэлгээ
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Баримт бичгийн жагсаалт
- Хүснэгт 2. Түүврийн төлөвлөлт
- Хүснэгт 3. Асуулга судалгаанд оролцогчдын нийгэм, хүн ам зүйн мэдээлэл
- Хүснэгт 4. 2013-2016 оны ОНЖТБХ хөтөлбөрийн төлөвлөлт
- Хүснэгт 5. ОНЖДХ-ийн хэрэгжээгүй үйл ажиллагаа
- Хүснэгт 6. ТББ-ийн хамтын ажиллагаа
- Хүснэгт 7. ОНЖДХ-ийн 2013-2016 онд хийгдсэн үйл ажиллагаанд хамрагдсан иргэд
- Хүснэгт 8. 2017-2020 онд аймгийн жендэрийн салбар хорооны зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдсан иргэд
- Хүснэгт 9. Зорилт 1-ийн хэрэгжилтийн байдал
- Хүснэгт 10. ОНЖДХ-ийн хэрэгжилт /1.3/
- Хүснэгт 11. ОНЖДХ-ийн хэрэгжилт /1.6/
- Хүснэгт 12. ОНЖДХ-ийн хэрэгжилт /1.12/
- Хүснэгт 13. Зорилт 2. Хэрэгжсэн үйл ажиллагаа
- Хүснэгт 14. ОНЖДХ-ийн хэрэгжилт/2.1/
- Хүснэгт 15. Зорилт 3. Хэрэгжсэн үйл ажиллагаа
- Хүснэгт 16. ОНЖДХ-ийн хэрэгжилт/3.2/
- Хүснэгт 17. Зорилт 3.1 Хэрэгжсэн үйл ажиллагаа
- Хүснэгт 18. ОНЖДХ-ийн хэрэгжилт/3.1.5/
- Хүснэгт 19. Зорилт 3.2 Хэрэгжсэн үйл ажиллагаа
- Хүснэгт 20. Зорилт 3.3 Хэрэгжсэн үйл ажиллагаа
- Хүснэгт 21. Зорилт 3.4 Хэрэгжсэн үйл ажиллагаа
- Хүснэгт 22. Зорилт 3.5 Хэрэгжсэн үйл ажиллагаа
- Хүснэгт 23. ОНЖДХ-ийн хэрэгжилт/3.5/
- Хүснэгт 24. Жендэрийн тухай ойлголт /Асуулгын үр дүн/
- Хүснэгт 25. Жендэрийн асуудал хаана их гарч байна вэ
- Хүснэгт 27. ОНЖДХ-т иргэдийн санал

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. ОНЖДХ-ийн хэрэгжсэн, хэрэгжээгүй үйл ажиллагааны тоо /2013-2016/
- Зураг 2 Жендэрийн салбар хорооны үйл ажиллагааны хэрэгжилт 2017-2020
- Зураг 3. Жендэрийн мэдлэг олгох үйл ажиллагаанд оролцсон байдал
- Зураг 4. Жендэрийн мэдээлэл авдаг эх сурвалж
- Зураг 5. Түр хамгаалах байраар үйлчлүүлэгчийн тоо
- Зураг 6. ОНЖДХ-ийн талаарх иргэдийн мэдлэг
- Зураг 7. Жендэрийн талаар мэдээлэл авсан эх сурвалж

ТАЛАРХАЛ

Булган аймгийн Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл болж Жендэрийн үндэсний хороо, Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй хэрэгжүүлж буй “Иргэний нийгмийн оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь” төслийн хүрээнд Булган аймгийн Жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрт оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх боломжийг олгосонд талархал илэрхийлж байна. Оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлсэн зөвлөхүүд С.Түмэндэлгэр, Ц.Одгэрэл, Т.Бүрэнжаргал багш нартаа талархал илэрхийлье.

Орон нутагт ЖЭТБХДХ-ийн хэрэгжилтийг үнэлэхэд судалгаа авах, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага хийхэд зохион байгуулалт хийж туслалцаа үзүүлсэн Булган аймгийн Орхон сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан Б.Цогбадрах, Гурванбулаг сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан С.Өлзийхутаг, Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан М.Оюунтунгалаг, Сайхан сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан Ц.Хулганаа, Бугат сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан Л.Оюунгэрэл, Булган сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан О.Цэрэнлхам нарт болон санал асуулга, бүлгийн ярилцлагад оролцож үнэтэй мэдээлэл өгсөн орон нутгийн иргэд, удирдах ажилтнуудад чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

ОХШҮ-ний баг

ОХШҮ-НИЙ ХУРААНГУЙ

Булган аймгийн Гэрэлт Ирээдүй Оршихуй ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Оргил Мээж хоршоо, Ажил олгогч эздийн холбоо зэрэг ИНБ-уудаас бүрдсэн ОХШҮ-ний баг 2020 оны 10 сараас эхлэн 2021 оны 01 сарын 25 хүртэлх хугацаанд Булган аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажиллалаа. ОХШҮ-ний зорилго нь ОНЖДХ-ийн төлөвлөлт, хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнг тодорхойлж дараагийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхэд сайжруулах асуудлыг тодорхойлох юм.

ОНЖДХ-өөр дэвшүүлсэн зорилго, зорилтууд нь Булган аймгийн онцлог, иргэдэд тулгамдаж буй асуудалд анхаарч чадсан эсэх, дэвшүүлсэн асуудлыг хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөсөн, оролцогчид, үр шим хүртэгчид нь хэн байсан, хэнд чиглүүлсэн, хэдий хугацаанд, ямар эх үүсвэрээс санхүүжүүлсэн, хэрэгжилтийг хэн хангаж ажилласан, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хэрхэн хийсэн, ямар, ямар үйл ажиллагааг төлөвлөсөн, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь хэр үр дүнтэй байсан, цаашид засаж сайжруулах асуудлын хүрээг тодорхойлох зэрэг зорилтуудыг дэвшүүлж ажилласан.

ОНЖДХ-т оролцооны хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалын дагуу орон нутгийн шийдвэр гаргагчид, жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан ажиллаж байгаа мэргэжилтэн, орон нутгийн иргэдтэй бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага хийх, иргэдээс асуулга судалгаа авах, хөтөлбөрийн хүрээнд гарсан баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх арга замуудаар мэдээллүүдийг цуглуулж орон нутагт тулгамдаж буй жендэрийн асуудал, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн чадамж, ОНЖДХ-ийн төлөвлөлтийн уялдаа, хөтөлбөрийн хэрэгжилтэд орон нутгийн удирдах албан тушаалтны үүрэг, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулж буй үйл ажиллагаа, үр нөлөө, иргэд олон нийтийн ойлголт мэдлэгт хэрхэн нөлөөлсөн зэрэгт дүн шинжилгээ хийсэн.

ОНЖДХ-нь 4 зорилт, 5 дэд чиглэлийн хүрээнд 65 үйл ажиллагааг төлөвлөж, төлөвлөгдсөн үйл ажиллагаанаас 56 буюу нийт төлөвлөсөн арга хэмжээний 86% хэрэгжсэн, 9 үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна. Төлөвлөөгүй хэрэгжүүлсэн үйл ажиллагаа байхгүй. ОНЖДХ-ийн хүрээнд төлөвлөгдөөд хэрэгжсэн үйл ажиллагаанаас Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэд Түр хамгаалах байр, гэр бүлд зөвлөгөө өгөх төв, Аймгийн нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинет байгуулагдсан нь иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ажил болсон байна.

Оролцооны үнэлгээний үр дүнд орон нутгийн иргэдээс авсан асуулгаас үзэхэд судалгаанд оролцогчдын 9.8% жендэрийн талаар зөв ойлголттой, 12.8% нь ОНЖДХ-ийг мэддэг буюу хөтөлбөрийн талаар сонсож байсан, 21.1% нь жендэрийн талаар мэдлэг олгох сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, үйл ажиллагаанд оролцож байсан байна. Бүлгийн ярилцлагын оролцсон иргэдийн дийлэнх нь жендэрийн тухай мэдэхгүй, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн талаар сонсож байгаагүй гэж хариулсан нь жендэрийн талаар сургалт мэдээлэл хангалтгүй зохион байгуулагдсан, зохион байгуулсан үйл ажиллагаа иргэдэд хүртээмжтэй биш байгааг харуулж байна.

ОШХҮ-ний мэдээлэл цуглуулах явцад ОНЖДХ-ийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд хүргэхдээ төрийн захиргааны байгууллага, агентлагуудыг татан оролцуулж, тэдэнд мэдээлэл хүргэж, хэвлэл мэдээллийнхэн, ИНБ, алслагдсан сумууд болон нийгмийн идэвх сул иргэдэд хүргэх, тэднийг татан оролцуулах тал дээр төдийлөн сайн ажиллаж чадаагүй байна гэж дүгнэлээ.

Ганцаарчилсан ярилцлагад оролцогч мэргэжилтэн, удирдлагуудын өгсөн мэдээллээс ОНЖДХ-ийн төлөвлөлт орон нутагт тулгамдаж буй асуудалд тулгуурлаж хийгдсэн байдал хангалтгүй, сумдад хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж салбар зөвлөл байгуулагдаагүй, төсөв хөрөнгө төлөвлөөгүй нь хөтөлбөрийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байгаа тул цаашид ОНЖДХ-ийн төлөвлөлтийг сайжруулж, орон нутагт тулгамдаж буй асуудалд тулгуурлах, төсөв санхүүг нэмэгдүүлэх, орон нутгийн жендэрийн салбар хороог идэвхжүүлэх, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, салбар хорооны гишүүд, орон нутгийн удирдлагуудын ойлголтыг нэмэгдүүлж чадваржуулах, нийгмийн бүлгүүдэд үйл ажиллагааг чиглүүлэх талаар бодлогын зөвлөмжийг боловсруулж ажиллалаа.

Нэг. УДИРТГАЛ

1.1 Үндэслэл

Булган аймаг ЖЭТБХДХ-ийг 2013-2016 онд батлан хэрэгжүүлсэн ба 2016 онд аймгийн ИТХ-аар хэрэгжилтийг хэлэлцэж 2016-2020 онд дахин хэрэгжүүлэх шийдвэр гаргасан. 2017-2020 онд хэрэгжсэн дэд хөтөлбөрт хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй. Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд ИНБ хяналт, шинжилгээ үнэлгээ хийх нь аль нэгэн талын нөлөөлөлд автахгүйгээр төрийн үйлчилгээг хүлээн авагч иргэдийн төлөөлөл болж чадах төдийгүй хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг бодитоор дүгнэн, амжилт ололт, алдаа оноог танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах талаар иргэдийн саналыг орон нутгийн удирдлагуудад бодитоор хүргэх, зөвлөгөө зөвлөмж өгөх, хэрэгжилтийг хамтран зохион байгуулах давуу талуудтай.

Жендэрийн үндэсний хорооноос ОНЖДХ-т оролцооны хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд орон нутгийн ИНБ-уудыг чадваржуулах сургалтыг 2020 оны 9 дүгээр сард зохион байгуулснаар Булган аймагт үйл ажиллагаа явуулж байгаа ИНБ-уудын төлөөлөл хамрагдаж ОХШҮ хийх арга зүйд суралцсан. Өөрсдийн суралцсан арга зүйн дагуу Булган аймгийн ОНЖДХ-ийн хэрэгжилтэд ОХШҮ саналыг ЖҮХ-д хүргэн, Жендэр, хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөх багийн дэмжлэгтэйгээр ХШҮ-г 2020 оны 11 дүгээр сараас 2021 оны 2 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд зохион байгууллаа.

1.2 Зорилго, зорилтууд

Зорилго: Булган аймгийн 2013-2016 онуудад хэрэгжсэн орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр, Булган аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар зөвлөлийн 2017-2020 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, нөлөөлөлд оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх

Зорилтууд:

- 2013-2016 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд анхаарч 2017-2020 оны төлөвлөлтийг сайжруулж чадсан эсэхийг тодруулах
- ОНЖДХ-ийн хэрэгжилтийн амжилт болон сул талыг тодорхойлох
- ОНЖДХ-ийн хэрэгжилтэд оролцогч талууд, үр шимийг хүртэгчдийн оролцооны байдлыг тодруулах
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр нөлөөг тодорхойлох үр шим хүртэгчид болон оролцогч талуудын оролцоог тодруулах

1.3 ОХШҮ-ний хамрах хүрээ

ОХШҮ-ний хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлж, мэдээллийг цуглуулан ажилласан. Үүнд:

- 2013-2016 оны хөтөлбөрийн хэрэгжилт яагаад хангалтгүй байсан бэ? Үүнийг 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хэрхэн сайжруулж хэрэгжүүлсэн бэ? Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд анхаарч төлөвлөлтийг сайжруулж чадсан уу?
- Хөтөлбөрийн хэрэгжилт ямар байв? Юуг сайн, юуг хангалтгүй хийв? Хөтөлбөрийн хэрэгжилтийн давуу болон сул тал юунд байв?
- Төлөвлөлт, хэрэгжилт хоёрын уялдаа ямар байсан бэ? Хөтөлбөрт тусгагдаагүй ажил хийгдсэн үү?

- Хэн үр шим хүртэв? Хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцогч талуудын оролцоог хэрхэн хангав?
- Хөтөлбөрийн хэрэгжилт ямар байв, хөтөлбөр хэрэгжсэний үр нөлөө юу байв? Хөтөлбөр олон нийтэд яаж хүрэв? Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд ямар өөрчлөлт гарсан бэ?

Хоёр. ОХШҮ-ний арга зүй

Оролцооны үнэлгээг баримт бичгийн дүн шинжилгээ, асуулгын арга, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар цуглуулсан мэдээлэлд тулгуурлан хийсэн. Оролцооны үнэлгээний хүрээнд ОНЖДХ-ийн талаар иргэдийн мэдлэг, хөтөлбөр нь орон нутагт жөндөрийн хувьд тулгамдаж буй асуудалд тулгуурлаж чадсан эсэх, иргэд олон нийтэд хэрхэн хүрч ажилласан болох, иргэдийн орон нутгийн жөндөрийн бодлого, хөтөлбөрийн талаарх мэдээлэлтэй байдал ямар байгаа болон цаашид жөндөрийн эрх тэгш байдлыг сайжруулахад ямар асуудалд анхаарч ажиллах талаар иргэдийн болон мэргэжилтнүүдийн санал бодлыг сонсож мэдээлэл цуглуулсан.

2.1 Мэдээлэл цуглуулах аргууд

ОХШҮ-ний мэдээллийг цуглуулахдаа дараах аргуудыг ашиглан зохион байгууллаа. Үүнд:

1. Баримт бичгийн дүн шинжилгээний арга
2. Асуулгын арга
3. Түлхүүр мэдээлэгчийн ярилцлага буюу ганцаарчилсан ярилцлагын арга
4. Бүлгийн ярилцлагын арга

Булган аймгийн 16 сумаас төлөөлүүлэн аймгийн төвийн сум болон газар зүйн байршлаар бүсчилэн урд, хойд, баруун бүс бүрээс нийт 6 сумыг хамруулж, ОХШҮ-ний мэдээллийг цуглуулав.

2.1.1 Баримт бичгийн шинжилгээний арга.

Баримт бичгийн дүн шинжилгээний аргаар ОНЖДХ-ийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн ИТХ, засаг даргын гаргасан захирамж, тогтоол, шийдвэрүүд, батлагдсан төлөвлөгөө, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хугацаа, төсөв санхүүжилт, хэрэгжүүлэгч байгууллага, оролцогчид, ТББ болон хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо зэрэг мэдээллийг нягтлахаар дараах 11 төрлийн баримт бичигт дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

Хүснэгт 1. Баримт бичгийн жагсаалт

№	Баримт бичиг
1	Аймгийн ИТХ-ын тогтоол ОНЖДХ баталсан тухай 2013
2	Булган аймгийн Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр 2013-2016
3	Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан 2013-2016
4	Аймгийн засаг даргын захирамж аймгийн жөндөрийн эрх тэгш байдлыг хангах салбар зөвлөл байгуулах тухай 2013, 2017 он
5	Аймгийн жөндөрийн салбар зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөө 2017-2020
6	Аймгийн жөндөрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан 2017-2020
7	Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан 2019, 2020

8	Хүний эрхийн үндэсний комиссын зөвлөмж
9	Хүний эрхийн тайлан 2019, 2020
10	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны тайлан 2019, 2020
11	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын тэмдэглэл 2016 он

2.1.2 Асуулгын арга

Асуулгын аргаар нийт 133 иргэнээс цаасаар мэдээлэл цуглуулсан ба иргэдийн жендэрийн ойлголт мэдлэг, орон нутагт тулгамдаж буй жендэрийн асуудал, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн талаарх мэдлэг мэдээлэл, хөтөлбөрийн хэрэгжилт, жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаа дахь оролцоо, иргэд орон нийтийн жендэрийн асуудалд хандах хандлагыг тодорхойлох агуулга бүхий 16 асуулттай судалгаа авсан.

Асуулгыг Булган, Орхон, Гурванбулаг, Сайхан, Бугат, Сэлэнгэ зэрэг сумын иргэдийн төлөөллөөс авсан.

2.1.3 Ганцаарчилсан ярилцлага

Ганцаарчилсан ярилцлагад ОНЖДХ-ийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг хариуцлага бүхий удирдах ажилтан, мэргэжилтнүүдийг хамрууллаа. Үүнд Булган, Сэлэнгэ, Сайхан, Бугат, Орхон сумын удирдах ажилтан, нийгмийн ажилтан, Булган аймгийн жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, аймгийн хүний эрх хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулж, орон нутагт тулгамдаж буй жендэрийн асуудал, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн чадамж, ОНЖДХ-ийн төлөвлөлтийн уялдаа, хөтөлбөрийн хэрэгжилтэд орон нутгийн удирдах албан тушаалтны үүрэг, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулж буй үйл ажиллагаа, үр нөлөө, иргэд олон нийтийн ойлголт мэдлэг, цаашид анхаарах асуудлыг тодруулан нийт 13 ярилцлага зохион байгуулав.

2.1.4 Бүлгийн ярилцлага

Бүлгийн ярилцлагыг аймгийн төвийн Булган, Гурванбулаг, Орхон, Сэлэнгэ, Сайхан, Бугат сумын иргэд болон мэргэжилтэн, нийт 7 холимог бүлгээс авсан. Бүлгийн ярилцлагад боловсрол, эрүүл мэнд, ЗДТГ-ын албан хаагч, малчин, өндөр настан, нийгмийн халамж авдаг, ажилгүй зэрэг салбар бүрийн төлөөлөл болох 21-62 насны 21 эрэгтэй, 21 эмэгтэй, нийт 42 иргэн оролцуулсан. Бүлгийн ярилцлагын аргаар иргэдийн жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг, орон нутгийн жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн ойлголт мэдлэг, хэн үр шим хүртэж, нийгмийн ямар бүлэг үр шим хүртэж чадахгүй байгаа, орон нутагт тулгамдаж буй жендэрийн асуудлуудыг тодруулсан. Булган суманд холимог бүлгээс гадна зөвхөн төрийн байгууллагад ажилладаг мэргэжилтнүүдийг оролцуулсан бүлгийн ярилцлага зохион байгуулсан нь төрийн албан хаагчид өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд жендэрийн талаар мэдлэгтэй байгаа эсэхийг тодруулахыг зорьсон.

2.2 Түүвэрлэлт

ОХШҮ-нд нийт 133 өрхийг хамруулав. Асуулгын судалгааны түүврийг хийхдээ чанарыг баталгаажуулах багцын түүвэрлэлтийн арга буюу LQAS аргаар Орхон, Гурванбулаг, Сайхан, Бугат, Сэлэнгэ сум бүрийг нэг багцад тооцож, өрхийн жагсаалтаас багц бүрээс 19 өрхийг, Булган сумыг 2 багц болгон хэсэг тус бүрээс 19 нийт 38 өрх сонгосон. Сумдын түвшинд зөвхөн сумын төвийн өрхөөс түүвэрлэж нийт 133 өрхөөс асуулгын аргаар мэдээлэл цуглуулав. Бүлгийн ярилцлагад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, малчин, оюутан, ажилгүй иргэн, нийгмийн халамж авдаг буюу тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсан тэтгэмж болон бусад тэтгэмж авдаг иргэн гэсэн нийгмийн бүлгүүдээс хамруулахыг зорьсон. Хөдөө орон нутагт төрийн албан хаагчдыг

хамруулахдаа төрийн захиргааны ажилтан, боловсрол, эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг хамруулсан.

Ганцаарчилсан ярилцлагад сумын засаг дарга 5, тамгын газрын дарга 1, сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан 5, аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн болон хүний эрхийн мэргэжилтнийг хамруулсан.

Хүснэгт 2 Түүврийн төлөвлөлт

№	Сумын нэр	Асуулгын түүвэр	ГЯ-ын түүвэр	БЯ-ын түүвэр
1	Булган	38	4	2
2	Орхон	19	2	1
3	Бугат	19	2	1
4	Гурванбулаг	19	1	1
5	Сайхан	19	1	1
6	Сэлэнгэ	19	2	1
7	Рашаант		1	
	Нийт	133	13	7

Хүснэгт 3. Асуулга судалгаанд оролцогчдын нийгэм, хүн ам зүйн мэдээлэл

Сонгосон үзүүлэлт	Тоо	Хувь
Хүйс		
Эрэгтэй	59	44.4%
Эмэгтэй	74	55.6%
Боловсролын байдал		
Дээд	67	50.4%
Тусгай дунд	13	9.8%
Бүрэн дунд	38	28.6%
Бүрэн бус дунд	13	9.8%
Бага	2	1.5%
Ажил эрхлэлтийн байдал		
Төрийн албан хаагч	51	38.3%
Хувийн хэвшлийн ажилтан	14	10.5%
Малчин	26	19.5%
Ажилгүй	18	13.5%
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	7	5.3%
ТББ-ын ажилтан	4	3%
Тэтгэвэр, тэтгэмж авдаг иргэн	6	4.5%
Оюутан	3	2.3%
Амьдарч буй газар		
Аймгийн төвд	34	25.6%
Сумын төвд	78	58.6%
Хөдөөд	21	15.8%

2.3 Мэдээлэл цуглуулалтын үйл ажиллагаа

Ковид-19 цар тахлын хөл хорионы нөхцөл байдлаас мэдээлэл цуглуулах ажлыг Булган аймгийн 6 сумыг оролцуулан 2020 оны 12-р сарын 14-25-ны хооронд ОХШҮ-ний 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан. Багийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг дараах байдлаар хуваарилж ажиллалаа.

Хүснэгт 4. Мэдээлэл цуглуулсан ажлын хуваарь

№	Сумын нэр	Хугацаа	Судалгаа	Бүлгийн ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага
---	-----------	---------	----------	-------------------	-------------------------

					Удирдлага	Мэргэжилтэн
1	Орхон	2020.12.17	Батзориг, С.Батхуяг	Н.Баянжаргал	Х.Нарангэрэл	Н.Баянжаргал
2	Сэлэнгэ	2020.12.19	Батзориг, С.Батхуяг	Н.Баянжаргал	П.Хишигдаваа	Н.Баянжаргал
3	Гурванбулаг	2020.12.22	Батзориг, С.Батхуяг	Н.Баянжаргал	П.Хишигдаваа	Н.Баянжаргал
4	Сайхан	2020.12.24	Батзориг, С.Батхуяг	Х.Нарангэрэл	Н.Баянжаргал	Н.Баянжаргал
5	Бугат	2020.12.26	Батзориг, С.Батхуяг	П.Хишигдаваа	Х.Нарангэрэл	Х.Нарангэрэл
6	Булган	2020.12.27	Батзориг, С.Батхуяг	П.Баянжаргал	П.Хишигдаваа	Х.Нарангэрэл

Цар тахлын нөхцөлд сумын онцгой комиссоос айл өрхөөр зочлохгүй байх шаардлага тавьж байсан тул мэдээлэл цуглуулахад бэрхшээлтэй байсан. Иймд ОХШҮ-ний баг асуулга судалгаанд санамсаргүйгээр сонгогдсон хүн амыг ариутгал халдваргүйтгэл хийсэн өрөөнд ирүүлж мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулсан.

Бүлгийн ярилцлагыг зохион байгуулахдаа цар тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг баримтлан нэг дор цөөн хүн цуглуулах, хүн хоорондын зайг баримтлах, амны хаалт зүүх зэрэг халдвар хамгааллын дүрмийг баримтлан ажилласан.

Ганцаарчилсан ярилцлагад оролцох удирдах ажилтан болон мэргэжилтнүүдийг сонгохдоо хүйс, ажилласан жил, туршлагыг харгалзан олон талаас нь мэдээлэл олж авахыг зорьсон. Мэдээлэл цуглуулах явцад ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллахыг зарчим болгон судалгаа болон ярилцлагад оролцогчдын зөвшөөрлийг авч сайн дурын үндсэн дээр оролцуулсан. Судалгаанд оролцогчдын хувийн мэдээллийг авахгүй зөвхөн ерөнхий мэдээллийг авч судалгааны үр дүнд ашиглах ба оролцогчийн өгсөн мэдээллийг гадагш задруулахгүй байх талаар урьдчилан илэрхийлсэн. Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагад оролцогчийн санал бодлыг бүрэн сонсож тэдний хэлсэн зүйлийн буруу зөвийг хэлэлцэхгүй, мөн бусад оролцогчийн санал бодлыг хүлээцтэй бүрэн сонсохыг ярилцлага эхлэхийн өмнө бүх оролцогчдод тайлбарласан.

Бүлгийн ярилцлага хөтлөх явцад оролцогчдын жендэр, жендэрийн эрх тэгш байдлын мэдлэг хангалтгүйгээс орон нутагт тулгамдаж буй жендэрийн асуудлын талаар санал бодлоо илэрхийлэхэд нь хөтлөгчийн зүгээс жендэрийн асуудлаар чиглүүлэх зэргээр оролцогчдод сэдэл өгч ярилцлагыг өрнүүлсэн.

2.4 Зөвлөлдөх уулзалтууд

Олон нийттэй зөвлөлдөх уулзалтыг 2 удаа зохион байгуулахаар төлөвлөсөн. Эхний уулзалтыг 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Зөвлөлдөх уулзалтад Булган аймгийн ИНБ болон төрийн байгууллагын төлөөллүүд оролцсон. Оролцогчид ИНБ-уудын оролцоотойгоор төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт хийх болсонд талархалтай байгаагаа илэрхийлсэн. Мөн иргэд жендэрийн талаар ойлголт мэдлэг муутайгаас жендэрт суурилсан хүчирхийлэл их гарч байгаа, ажлын байран дээр хүйсээс хамааралтай гадуурхалт байгаа нь нөлөөллийн ажил хангалтгүй байгаагийн илрэл. Энэ мэтчилэн асуудлыг илрүүлж дараагийн хөтөлбөрт оруулах нь чухал байгааг онцолсон.

2 дахь зөвлөлдөх уулзалтыг “ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ”-ний тайланг танилцуулах санал зөвлөмж авахаар зохион байгуулсан. Зөвлөлдөх уулзалтат Булган аймгийн засаг дарга, засаг даргын орлогч дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, аймгийн ЗДТГ-ын дарга, Нийгмийн бодлогын хэлтэцсийн дарга, засаг даргын зөвлөх, аймгийн жендэрийн салбар зөвлөлийн гишүүд, зарим төрийн байгууллагын удирдлага болон төлөөлөл, ИНБ-ын төлөөлөлүүд нийт 20 хүн оролцлоо. Мөн Булганы мэдээ сонин, Сайхан Монгол телевиз оролцож олон нийтэд мэдээлэл түгээн ажилласан.

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хийсэн “Оролцооны хяналт шинжилгээ үнэлгээ”-ний ажлын үр дүнг ОХШҮ-ний багаас танилцууллаа. Танилцуулгад ОХШҮ-ний зорилго зорилт, хамрах хүрээ, мэдээлэл цуглуулсан арга зүй, ОХШҮ-ний явцад илэрсэн гол ололтууд, дүгнэл, зөвлөмжийг танилцуулж оролцогчид асуулт, хариулт, санал зөвлөмжөө хэлэлцлээ. Оролцогчид ОХШҮ-ний дүгнэлтүүдээс асууж тодруулан өөрсдийн тайлбар болон зөвлөмжүүдээ хэлсэн. Тухайлбал:

-2013-2016 онд бол жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр ихээхэн санаачлагатай ажилласан жилүүд байсан. Жишээ нь эмэгтэй төлөөлөгчдийн квотыг хэрэгжүүлэх лобби бүлэг байгуулах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үндэсний хэмжээний зөвлөгөөн хийх, эмэгтэйчүүдийн чуулга уулзалтууд зохион байгуулсан зэрэг томоохон масс арга хэмжээнүүд хийж багагүй төсөв хөрөнгө зарцуулж байсан. Үйл ажиллагааны тайлан мэдээнд зарцуулсан төсөв дурдагдаагүй учир ОХШҮ-ний явцад төсвийн талаарх мэдээлэл тусгагдаагүй байх.

Аймгийн удирлагууд дараах байдлаар ОХШҮ-ний үр дүнг дүгнэлээ.

Аймгийн Засаг дарга -оролцооны хяналт шинжилгээ үнэлгээ хийж багаар ажилласан ИНБ-ын оролцоонд талархаж байна. Цаашид ИНБ-уудын оролцоог хангаж, шаардлагатай арга хэмжээнүүдийг хамтарч хэрэгжүүлэхэд бэлэн байна. ОХШҮ-ны тайланд тусгагдсан, дэвшүүлж байгаа саналуудыг хүлээн авч дараагийн үйл ажиллагааны төлөвлөлтөд хэрэгжүүлж ажиллана.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга - Сумдад жендэрийн асуудал хариуцсан нэгж байх шаардлагатайг олж харлаа. Нөгөө талаар бүх салбарын хөтөлбөр, бодлогууд аймгийн жендэрийн салбар хороогоор хэлэлцэгдэж саналыг нь авч байвал ямар вэ гэсэн саналтай байна. Учир нь үнэхээр жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт хийгдэж байгаа эсэхийг энэ салбар хороо л зөвлөж чадна.

Уулзалтын төгсгөлд дараагийн жендэрийн дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхэд энэ удаагийн ОХШҮ-ний дүгнэлт, зөвлөмжүүд чухал ач холбогдолтойг үнэлж талархалаа илэрхийллээ.



Фото зураг 1. ОНЖДХ-ийн хэрэгжилтэд хийсэн ОХШҮ үр дүнг танилцуулах зөвлөлдөх уулзалт

Гурав. ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3.1 Оролцооны хяналт шинжилгээний үр дүн

Булган аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд баримт бичгийн шинжилгээний аргаар мэдээлэл цуглуулж, орон нутгийн удирдлага, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтний ганцаарчилсан ярилцлагаар баталгаажуулан дүн шинжилгээ хийлээ. Баримт бичгийн дүн шинжилгээг дараах баримт бичгийг үндэслэн хийлээ. Үүнд:

- Булган аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр 2013-2016
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан 2013-2016
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөө 2017, 2018, 2019, 2020 онууд
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан 2017, 2018, 2019 онууд
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан 2020 он

3.1.1. ОНЖДХ-ийн төлөвлөлт ба хэрэгжилт

Булган аймгийн ИТХТ-ийн 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 168 дугаар тогтоолоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн хөтөлбөрийг баталсан. ОНЖДХ нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, стратегийг хэрэгжүүлэх орон нутгийн чадавхыг бий болгох, эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, аймгийн нийгэм эдийн засгийн хөгжил, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцох, хөтөлбөрийн хэрэгжилтэд иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн оролцоог хангах замаар жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого, үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилготойгоор хэрэгжсэн байна.


Хүснэгт 5. 2013-2016 оны ОНЖТБХ хөтөлбөрийн төлөвлөлт

Зорилтууд	Үйл ажиллагааны чиглэл
Зорилт 1: Жендэрийн эрх тэгш байдлын хууль, стратегийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтан, ажилтан, төрийн бус байгууллагын удирдлага, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг чадавхжуулах, жендэрийн мэдээллийн сан бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> • Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хороо байгуулж, гишүүд, орон тооны бус ажилтан, ТББ-ын удирдлагыг чадваржуулах • Орон нутгийн түвшний шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч, хууль хэрэглэгчдэд зориулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх • Орон нутгийн бодлого, стратеги, төсөл, хөтөлбөрүүдэд жендэрийн дүн шинжилгээ хийх • Жендэрийн асуудлаар аймаг, сум, байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг бодлого боловсруулахад ашиглах
Зорилт 2: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын стратегийг	<ul style="list-style-type: none"> • Төрийн албан хаагчид, аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсадд жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой хууль, тогтоомж,

<p>сурталчлах, жендэрийн сургалт гэгээрлийн ажлаар олон нийтэд хүйсийн тэнцвэртэй байдлын талаарх зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлэх</p>	<p>стратегийг сурталчлах, сургалт зохион байгуулах, зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэгийн түвшинг тогтоох</p> <ul style="list-style-type: none"> • Насан туршийн боловсролын сургалтыг сум, байгууллагад зохион байгуулан ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглан иргэдэд жендэрийн мэдлэг, хандлага, ойлголт олгох, энэ ажилд ТББ-ыг танан оролцуулах, орон нутгийн хэвлэл, мэдээллийн нийтлэлийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгох, сонин, телевизүүд жендэрийн асуудлаар бие даасан булан, тусгай нэвтрүүлэгтэй болох
<p>Зорилт 3: Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, жендэрийн шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтыг улс төр, нийгэм, эдийн засаг, хөдөлмөр, гэр бүлийн харилцаанд хориглож, түүнээс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> • Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай иргэний гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, удирдамжийг хэрэгжүүлэх, гомдлын шийдвэрлэлтийг хянах • Төрийн алба, эрүүл мэнд, боловсрол хөдөлмөр, гэр бүлийн харилцаан дах жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлж, жендэрийн эрх тэгш байдал зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх
<p>Зорилт 4: Жендэрийн мэдрэмжтэй орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төсөв зохиох арга зүйг нэвтрүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> • Төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагч, ажил олгогч нарыг жендэрийн мэдрэмжтэй төсөв зохиох, арга зүйн сургалтад үе шаттайгаар хамруулах, гарын авлагаар хангах • Байгууллага, орон нутгийн төсөв нь жендэрийн мэдрэмжтэй байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт өгөх
<p>Эх сурвалж: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Булган аймгийн хөтөлбөр 2013-2016</p>	

2013-2016 оны ОНЖДХөтөлбөрийн төлөвлөгөө, хэрэгжилтийг шинжилж үзэхэд 4 зорилтын хүрээнд нийт 68 үйл ажиллагааг төлөвлөж, 3 зорилтын 39 үйл ажиллагааг 100% буюу бүрэн хэрэгжүүлсэн байна. Харин 3 зорилтын 20 үйл ажиллагааг тодорхой үр дүнд хүрсэн буюу 30-70% хэрэгжүүлсэн. 4 зорилтын 8 үйл ажиллагааг төлөвлөсөн боловч хэрэгжүүлээгүй байна. Хөтөлбөрийн 4 дэх зорилт буюу Жендэрийн мэдрэмжтэй төсөв гаргах зорилт бүхэлдээ хэрэгжээгүй байна. Харин 2017-2020 онуудад жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр шинээр боловсруулаагүй өмнөх хөтөлбөрийн хүрээнд жил жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан байна.

Зураг 1. ОНЖДХ төлөвлөгөөний хэрэгжилт



Эх сурвалж ОНЖДХ-ийн тайлан 2013-2016

Хүснэгт 6. ОНЖДХ-ийн хэрэгжээгүй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагаа	Хэрэгжээгүй шалтгаан
Зорилт 1. Жендэрийн эрх тэгш байдлын хууль, стратегийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хороог байгуулж, албан тушаалтан, ажилтан, хамтран хэрэгжүүлэх, хяналт тавих Төрийн бус байгууллагын удирдлага, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг чадавхижуулах, жендэрийн мэдээллийн сан бүрдүүлэх		
1	Орон нутгийн бодлого стратеги, төсөл хөтөлбөрүүдэд жендэрийн дүн шинжилгээ хийх ажлыг ТББ-уудаар хийлгэх	Төсөв санхүүжилт шийдээгүй тул хийгдээгүй.
Зорилт 2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын стратегийг сурталчлах, олон нийтэд хүйсийн тэнцвэртэй байдлын талаарх зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлэх		
2	Орон нутгийн хэвлэл, ТВ-үүд мэдээлэл нийтлэлийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгох, жендэрийн асуудлаар бие даасан булан, тусгай нэвтрүүлэгтэй болох	Тогтмол үйл ажиллагаатай орон нутгийн телевиз байхгүй байсан тул хийгдээгүй.
3	Сэтгүүлч, сурвалжлагч нарыг жендэрийн асуудлаар мэргэшүүлэх сургалтад хамруулах	Орон нутагт бэлтгэгдсэн сэтгүүлч, сурвалжлагч байхгүй
Зорилт 3. Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, жендэрийн шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтыг улс төр, нийгэм эдийн засаг, хөдөлмөр, гэр бүлийн харилцаанд хориглох, түүнээс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлэх		
4	Банк санхүүгийн салбарын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдэд ээлтэй жижиг зээлийн шинэ төрөл хэлбэрийг нэвтрүүлэх	Шалтгаан тайланд тусгагдаагүй
5	Эрэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулах	Төсөв санхүүжилт байхгүйгээс хийгдээгүй.
Зорилт 4. Жендэрийн мэдрэмжтэй төсөв зохион арга зүйг байгууллага, орон нутгийн төсвийг боловсруулах батлахад нэврүүлэх		
6	Төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагч, ажил олгогч, төсвийн	Төсөв, санхүүжилт байхгүйгээс хийгдээгүй

	мэргэжилтэн, төрийн сангийн ажилтан нарыг жендэрийн мэдрэмжтэй төсөв зохиох арга зүйн сургалтад үе шаттайгаар хамруулах	
7	Байгууллага орон нутгийн төсөв нь жендэрийн мэдрэмжтэй байгаа эсэхэд хяналт шинжилгээг ТББ-аар хийлгэж, үнэлгээ дүгнэлт өгүүлэх	Төсөв, санхүүжилт байхгүйгээс хийгдээгүй,
8	Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг аймаг сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд жендэрийн мэдрэмжийн үнэлгээ, дүгнэлтийг хамт оруулж байх.	Төсөв санхүүжилт байхгүйгээс хийгдээгүй
Эх сурвалж. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан 2013-2016		

Хүснэгт 5-аас дүгнэж үзэхэд зохион байгуулагдаагүй нийт 8 үйл ажиллагаануудын 7 нь төсөв, санхүүжилт шийдэгдээгүй улмаас хийгдээгүй байна. 1 арга хэмжээ нь үйл ажиллагааны зорилтот бүлэг буюу орон нутгийн телевиз, телевизийн сэтгүүлч байхгүйн улмаас хийгдээгүй байна.

2017-2020 онуудад аймгийн жендэрийн салбар хороо жил жилийн төлөвлөгөө гарган 4 зорилтын хүрээнд 15-18 ажил төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Төлөвлөгөөндөө төрийн байгууллагын албан хаагчид, эрүүл мэнд, боловсрол, гэр бүл, хөдөлмөр эрхлэлтийн салбар дахь жендэрийн судалгаа, тоо мэдээ гаргах, дээрх салбаруудад жендэрийн эрх тэгш байдлыг хангах, сумдын болон албан байгууллагын удирдлага, албан хаагчид, иргэдэд жендэрийн боловсрол олгох ажлууд тусгасан байна. Эдгээрийн хэрэгжилтийг тооцож үзэхэд 2019 онд төлөвлөгдсөн сумдад орон тооны бус салбар хороодыг байгуулж, удирдлага арга зүйгээр хангах, сургалтад хамруурлан мэргэшүүлэх ажил төсөв санхүү шийдэгдээгүй улмаас хийгдээгүй байна.



Эх сурвалж: Жендэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, 2017-2020

Дээрх үнэлгээг харахад төрийн байгууллагын үнэлгээгээр, 2017-2020 онд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төлөвлөсөн ажлуудыг төрийн байгууллага хангалттай хэрэгжсэн гэж дүгнэгджээ. 2020 онд жендэрийн салбар хороо 18 ажил хийхээр төлөвлөсөн байна. Гэвч жилийн эцэст тайлангаа Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд гаргасан тул 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцох боломжгүй байна.

2013-2016 оны аймгийн ЖЭТБХ хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд дурдсанаар дараах ТББ-уудтай хамтран ажилласан байна.

Хүснэгт 7. ТББ-ийн хамтын ажиллагаа

№	Төрийн бус байгууллага	Хамтын ажиллагааны хэлбэр
---	------------------------	---------------------------

1	“Өөдөө тэмүүл” ТББ	Эмэгтэйчүүдэд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах
2	ЛЭОС ТББ	Эмэгтэйчүүдэд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах
3	ДЗМОУБ	Гэр бүлийн харилцааны чиглэлээр хөдөө орон нутагт сургалт зохион байгуулах
4	Сайхан Монгол урсгал ТББ	Архины хор хөнөөлийн талаар сургалт зохион байгуулах
5	Зарц удирдагч ТББ	Эрчүүдэд зориулсан сургалт зохион байгуулах
6	Мэнд сайн ТББ	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэг хийх

ОНЖДХ-ийн хүрээнд зохион байгуулагдсан үйл ажиллагаа болон хамруулсан иргэдийг баримт бичигт тулгуурлан дараах байдлаар гаргалаа.

Хүснэгт 8. ОНЖДХ-ийн 2013-2016 онд хийгдсэн үйл ажиллагаанд хамрагдсан иргэд

№	Хийгдсэн үйл ажиллагаа	Хамрагдсан хүн	Төсөв	Зохион байгуулагч
1	Эмэгтэйчүүдийн манлайлал сургалт зохион байгуулсан	510		
2	“Хувь хүний төлөвшил, гэр бүл” сэдэвт сургалт хийсэн	11000		ГБХЗХГ
3	Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, Гэр бүлийн үнэ цэнэ сэдэвт сургалт хийсэн	20000		ГБХЗХГ
4	Залуу малчдыг малжуулах хөтөлбөрийн хүрээнд залуу малчдыг малжуулсан	196 өрх	808,8 сая	
5	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр”, “40-өөс дээш ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” ийн хүрээнд зорилтот бүлэг дэмжлэг үзүүлсэн	131	138 сая	ГБХЗХГ, ХХҮГ
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн мэргэжлийн ур чадвар олгох сургалт зохион байгуулсан	43		ХХҮГ
7	Хөдөөгийн эмэгтэйчүүдийн бүлэг давамгайлсан бэлчээрийн менежментийн удирдлагын хөгжлийн төсөлд эмэгтэйчүүдийг хамруулсан	90 бүлэг	396 сая	ХХҮГ
8	Өрх толгойлсон олон хүүхэдтэй, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой эцэг эхчүүдийг дэмжих сум, байгууллагын хөтөлбөр хэрэгжүүлсэн	305		Сайн үйлсийн аян
9	Гэр бүлийн боловсрол олгох нөлөөллийн аян хийсэн	18600		ГБХЗХГ
10	Манлайлагч эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулсан	320		

11	Эрэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг хийсэн	1960		ЭМГ, сумдын ЭМТ
12	Иргэдэд халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд сургалт зохион байгуулсан	60927		ЭМГ
13	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа өрнүүлсэн	34095		ГБХЗХГ
14	100 аавын сургалт зохион байгуулсан	1600		ЦГ, ГБХЗХГ
15	Нүүдлийн амбулаторийн үзлэг хилийн анги, цэргийн 2 заставд ажилласан	205 хилчин		Нэгдсэн эмнэлэг
16	Эцэг эх, өсвөр үеийнхэнд чиглэсэн сургалт зохион байгуулсан	8350		БСУГ, ЭМГ, ЦГ, ГБХЗХГ
17	Өсвөр үеийн кабинет байгуулсан	420 хүүхэд		Нэгдсэн эмнэлэг
18	Насан туршийн боловсрол төвөөр дамжуулан иргэдэд боловсрол олгох сургалт зохион байгуулсан	320		БСУГ
Эх сурвалж: ЖЭТБХ аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан 2013-2016				

Хүснэгт 8-д дурдснаар 2013-2016 онд хэрэгжсэн ОНЖДХ-ийн хэрэгжилтэд Булган аймгийн БСУГ, ГБХЗХГ, ЭМГ, ЦГ, Нэгдсэн эмнэлэг, сумдын ЭМТ-үүд оролцож олон нийтэд үйлчилсэн байна. 2013-2016 оны ОНЖДХ-ийн тайланд дүн шинжилгээ хийхэд нийт хэрэгжсэн 56 үйл ажиллагааны 18 үйл ажиллагаа нь иргэд олон нийтийг хамруулсан буюу тайланд оролцогчийн тоо дурдсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд үйл ажиллагаа бүрт зарцуулсан мөнгөн дүнг тавиагүйгээс 2013-2016 онд ОНЖДХ-ийг хэрэгжүүлэхэд хичнээн хэмжээний хөрөнгө санхүү зарцуулсныг тооцох боломжгүй байна.

Хүснэгт 9. 2017-2020 онд аймгийн жөндөрийн салбар хорооны зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдсан иргэд

№	Зохион байгуулсан үйл ажиллагаа	Хамрагдсан хүн	Зохион байгуулагч
1	Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын сургалт, сурталчилгааны ажил хийсэн	5300	ГБХЗХГ, ЦГ, хамтарсан баг
2	Мэргэжил олгох сургалт зохион байгуулсан	84	ХХҮГ
3	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр залуу малчдыг малжуулсан	122	ХХҮГ
4	Аз жаргалтай гэр бүл аян өрнүүлсэн	11468	ГБХЗХГ, Сумдын ЗДТГ
5	Гэр бүлийн боловсрол олгох сургалт зохион байгуулсан	1241	ГБХЗХГ
6	Аавуудын үүрэг оролцоо сургалт зохион байгуулсан	660	ДЗМОУБ
7	Гэр бүлийн үнэ цэнэ лекц зохион байгуулсан	380	ГБХЗХГ
8	Түр хамгаалах байр тохижуулан ашиглалтад оруулсан	78	ГБХЗХГ
9	Сэтгэл зүйч бэлтгэх сургалт зохион байгуулсан	85	ГБХЗХГ

10	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян өрнүүлсэн	16 суманд	Сумдын ЗДТГ, ГБХЗХГ
11	Төрийн байгууллагын эрэгтэй албан хаагчдын Эрчтэй өглөө уулзалт зохион байгуулсан	80	ГБХЗХГ, АЗДТГ, ЦГ
12	Нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинет нээсэн	100	Нэгдсэн эмнэлэг
13	Хүмүүжлийн эерэг арга сургалтыг эцэг эх, асран хамгаалагчдад зохион байгуулсан	7103	ГБХЗХГ
Эх сурвалж: Жендэрийн салбар хорооны үйл ажиллагааны тайлан 2018, 2019, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжлтийн тайлан 2020			

2013-2016 оны ОНЖДХ-ийн тайлан, 2017-2020 оны аймгийн жендэрийн салбар хорооны жил жилийн тайлангуудад үйл ажиллагаанд зарцуулсан төсөв мөнгийг дурдаагүй нь Булган аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд зарцуулсан нийт төсвийн хэмжээг тооцох боломжгүй байна.

Жендэрийн салбар хорооны нарийн бичгийн дарга 2013-2016 онд ОНЖДХ-ийг хэрэгжүүлэхэд зориулсан төсөв байгаагүй гэж ганцаарчилсан ярилцлагын үеэр тэмдэглэсэн.

Шигтгээ

“Төсвийн хувьд тусгайлсан төсөв баталж байгаагүй ч сүүлийн 2 жилд тодорхой хэмжээний төсөв (бага) тавьж өгсөн. Энэ нь төлөвлөгдсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд их дэмжлэг болсон”

Аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн.

ОНЖДХ-ийн үйл ажиллагаанд тусгайлсан төсөв тавиагүй ч хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагаануудыг хариуцсан байгууллагууд жилийн ажлын төлөвлөгөөнд төсвийн хамт оруулж хэрэгжүүлж ажиллаж байжээ. ОНЖДХ-ийн хэрэгжилтийг зорилт бүрээр баримт бичиг, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар цуглуулсан мэдээлэлд тулгуурлан харьцуулж шинжилсэн. Үүнд:

Зорилт 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, стратегийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтан, ажилтан, төрийн бус байгууллагын удирдлага, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг чадавхжуулах, жендэрийн мэдээллийн сан бүрдүүлэх.

Энэ зорилтод 2013-2016 оны ОНЖДХ-т 13 үйл ажиллагаа төлөвлөж 11 үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Энэ зорилтын хүрээнд ОНЖДХ-ийг хэрэгжүүлэх нэгж буюу салбар зөвлөлийг байгуулах, чадваржуулах, аймгийн хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээний сантай болох үйл ажиллагаа төлөвлөгдсөн.

Хүснэгт 10. Зорилт 1-ийн хэрэгжилтийн байдал

ҮА-ны дугаар	Төлөвлөгдсөн үйл ажиллагаа	Хэрэгжсэн эсэх	
		2013-2016	2017-2020
1.1	Жендэрийн асуудал эрхэлсэн аймаг, сумын хороодыг байгуулах, хорооны ажиллах дүрмийг батлах, нарийн бичгийн дарга нарыг урамшуулалтай болгох	Тийм	Тийм
1.2	Жендэрийн асуудал хариуцсан орон тооны бус ажилтныг аймаг, сум, байгууллагуудад томилуулах,	Тийм	Тийм

	ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг боловсруулан хүргүүлэх , сургалтад хамруулах		
1.3	Жендэрийн асуудал эрхэлсэн аймаг, сумын хорооны гишүүдийг чадавхжуулах үе шаттайгаар сургалтад хамруулах	Тийм	Тийм
1.4	Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, сумын ЗДТГ-ын дарга, байгууллагын дарга нарт зориулсан сургалтын хөтөлбөр гаргах, шаталсан сургалтыг зохион байгуулах	Тийм	Үгүй
1.5	Сумын Нийгмийн ажилтнуудыг жендэрийн асуудлаар мэргэшүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулах	Тийм	Тийм
1.6	Орон нутгийн бодлого, стратеги, төсөл, хөтөлбөрүүдэд жендэрийн дүн шинжилгээ, судалгаа хийх ажилд ТББ-уудыг сургаж, дадлагажуулах, шаталсан сургалтыг Үндэсний хороотой хамтран зохион байгуулах	Үгүй	Тийм
1.7	Нутгийн удирдлагын байгууллагуудын шийдвэрт жендэрийн үнэлгээ хийх аргачлал, шалгуур үзүүлэлтийг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулан, мөрдөх	Тийм	Үгүй
1.8	Жендэрийн асуудлаар орон нутгийн түвшинд хүйсээр ангилсан статистикийн мэдээ гарган аймаг, сум, байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэх, сангийн мэдээллийг ил тод болгон мэдээлэх, түүнийг бодлого боловсруулахад ашиглах	Тийм	Тийм
1.10	Улс төрийн намууд, төрийн захиргаа, төсөвт байгууллага, ААНБ зэрэг салбарын онцлогт тохирсон жендэрийн судалгаа хийх арга зүй, аргачлалд ТББ-уудыг мэргэжүүлэх, сургалтад хамруулах	Тийм	Үгүй
1.11	Жендэрийн мэдээ мэдээлэл, статистикийн мэдээг байгууллагууд хугацаанд нь Статистикийн хэлтэст хүргүүлж байх	Тийм	Тийм
1.12	Жендэрийн асуудлаар сургалт явуулах аймаг, сумын сургагч багш нарыг бэлтгэх, эрх олгох	Тийм	Үгүй

2013-2016 оны ОНЖДХ-ийг 2017-2020 онд үргэлжлүүлэх шийдвэрийг аймгийн ИТХТ-ийн хурлаар шийдвэрлэсэн. Аймгийн жендэрийн салбар зөвлөл Жендэрийн үндэсний хороотой зөвшилцөн шинээр хөтөлбөр боловсруулахгүй өмнөх хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаануудыг жил жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн талаар аймгийн жендэрийн салбар хорооны нарийн бичгийн дарга, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн ганцаарчилсан ярилцлагадаа дурдсан. Жендэрийн салбар хороо 2017-2020 оны төлөвлөгөөндөө 1 дүгээр зорилтын хүрээнд төлөвлөгдсөн үйл ажиллагаанаас 3 үйл ажиллагааг төлөвлөөгүй. Харин 1-р зорилтын 1.4 Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, сумын ЗДТГ-ын дарга, байгууллагын дарга нарт зориулсан сургалтын хөтөлбөр гаргах, шаталсан сургалтыг зохион байгуулах ажлыг 2020 онд төлөвлөсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

Зорилт 1-н хүрээд хэрэгжсэн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж дараах зүйлсийг онцоллоо. Үүнд:

- 2013-2016 онд хэрэгжсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 70 дугаар тогтоолоор

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хороог 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан хорооны дүрмийг баталсан байна. Харин сумдын хэмжээнд хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж байгуулагдаагүй, сумын засаг даргын тамгын газрын нийгмийн ажилтан давхар хариуцан ажилласан байна. 2017-2020 онд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах салбар хороо Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 13 дугаар тогтоолоор 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан. Салбар хороо мөн л сумдын түвшинд байгуулагдаагүй, мэргэжилтнүүд хариуцаж ажилласан байна. Энэ нь өмнөх 4 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтэд дүгнэлт хийж сайжруулах арга хэмжээ аваагүйг илтгэж байна.

Шигтгээ

“Суманд жендэр хариуцсан зохион байгуулалтын нэгж гэж байхгүй, сумын нийгмийн ажилтан хариуцаад л явж байгаа”

Гурванбулаг сумын засаг дарга

ОНЖДХ-ийн хэрэгжилтийг хангалтгүй гэж ганцаарчилсан ярилцлагад оролцсон сумдын удирдлагууд дүгнэсэн. Дараах шигтгээнд харуулснаар 2013-2016 онд ОНЖДХ-ийн 1.1 заалтын биелэлтийг 100 хувьтайгаар хэрэгжсэн хэмээн төрийн байгууллагын 2016 онд гаргасан ОНЖДХ-ийн тайланд дүгнэжээ. Гэхдээ тайланд дурдснаар зөвхөн жендэрийн эх тэгш байдлыг хангах аймгийн салбар зөвлөл байгуулагдсан байгаа ба сумдад жендэрийн асуудал хариуцах нэгжийн талаар дурдаагүй байна.

Шигтгээ

Үйл ажиллагаа 1.1: Жендэрийн асуудал эрхэлсэн аймаг, сумын хороодыг байгуулах, хорооны ажиллах дүрмийг батлах, нарийн бичгийн дарга нарыг урамшуулалтай болгох Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 70 дугаар тогтоолоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хороог 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан дүрмийг батлан хэрэгжүүлж байна. Тус салбар хорооны нарийн бичгийн даргаар аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн нийгмийн халамж, хамгаалал нийгмийн бүлгүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллах бөгөөд Жендэрийн Үндэсний хорооноос гаргасан 2012 оны 03 тоот тогтоолын дагуу 2013 оноос эхлэн ажил үүргийг хавсран гүйцэтгэх тушаал гарган зохих нэмэгдлийг олгож байна.

Биелэлт 100%

ОНЖДХ-ийг хэрэгжүүлэх нэгж буюу салбар хороод сумдад байгуулагдаагүй нь хэрэгжилтийг сулруулахад нөлөөлсөн хүчин зүйлүүдийн нэг болжээ.

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн орон тооны бус хорооны нарийн бичгийн даргыг албан ёсоор томилон, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн нийгмийн халамж, хамгаалал нийгмийн бүлгүүдийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, жендэрийн асуудлыг хавсран гүйцэтгүүлж, урамшууллыг шийдвэрлэсэн байна. /ЖЭТБХ-ийн тайлан 2013-2016/ Сумын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтний хувьд жендэрийн асуудал хариуцан ажиллаж байгаа боловч ажлын байрны тодорхойлолтод орсон зүйл заалт, урамшуулал байхгүй. Шалтгаан нь сумын ЗДТГ үйл ажиллагааны хүрээнд 42 үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж

ажилладаг. Эдгээр үндэсний хөтөлбөрүүдийн нэгд ч ажлын хэсэг, тусгайлсан төлөвлөгөө, төсөв байдаггүй. ЗДТГ нь үйл ажиллагаагаа үндэсний хөтөлбөрүүдтэй уялдуулж ажилладаг.

- Аймгийн ЗДТГ-ын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь 2014, 2016 онуудад жендэрийн Үндэсний хороо, ХНХЯ-аас хамтран зохион байгуулсан “Жендэрийн бодлого төлөвлөлт үйл ажиллагаа” сэдэвт сургалтад хамрагдсан. Салбар хорооны гишүүдийг чадваржуулах ажлын хүрээнд гишүүд нэг удаа УИХ-ын хүрээнд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь, эрх тэгш байдлын талаар уулзалт хэлэлцүүлэгт оролцсон талаар 2013-2016 оны ОНЖДХ-ийн тайланд дурдагдсан байна. 2017, 2018, 2019, 2020 оны жендэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайланд аймгийн жендэрийн салбар зөвлөлийн гишүүдийг сургалтад хамруулсан талаарх тайлан байхгүй байна. Харин аймгийн жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн ганцаарчилсан ярилцлага өгөх үедээ салбар хорооны дарга, аймгийн ЗДТГ-ын дарга зэрэг хэд хэдэн гишүүн ЖҮХ болон бусад газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан гэжээ. Сумдын түвшинд жендэрийн асуудал хариуцсан албан тушаалтан, ажилтанг жендэрийн эрх тэгш байдлын чиглэлээр чадавхжуулах ажил хангалтгүй байсан талаар ганцаарчилсан ярилцлагад оролцсон удирдах ажилтнууд болон сумын асуудал хариуцсан мэргэжилтнүүд дурдсан. 2013-2016 оны ОНЖДХ-ийн хэрэгжилтийн тайлангаас харахад сумдын нийгмийн ажилтнуудыг сургаж чадваржуулах ажлын хүрээнд 2013, 2015 онд сургалт зохион байгуулсан гарын авлага хэвлүүлсэн зэргээс өөрөөр тайланд дурдсан зүйл үгүй. Үр дүн тодорхойгүй байна.

Хүснэгт 11. ОНЖДХ-ийн хэрэгжилт /1.3/

Шигтгээ:	
Төрийн байгууллага:	ОХШҮ:
<i>Үйл ажиллагаа 1.3 Жендэрийн асуудал эрхэлсэн аймаг, сумын хорооны гишүүдийг чадавхжуулах үе шаттайгаар сургалтанд хамруулах</i>	
<i>Салбар хорооны гишүүдийг мэргэшүүлэх, улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын талаар мэдлэг мэдээлэл олгох зорилгоор УИХ-ын гишүүн С.Одонтуяатай уулзалт зохион байгуулан улс төрийн ялангуяа УИХ-ын хүрээнд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь, эрх тэгш байдлын талаар ярилцаж санал бодлоо солилцлоо. Үүнээс гадна Полиси төвийн захирал Г. Эрдэнэгэрэл, лектор Г. Чойжамц нарыг урьж эрүүл мэнд, боловсрол, цагдаа, соёлын болон төрийн албан хаагчид, иргэд олон нийтийн төлөөлөл болсон 510 эмэгтэйг хамруулан “Эмэгтэйчүүдийн манлайлал” сэдэвт лекц зохион байгууллаа.</i>	<i>Хэрэгжилтийн тайлан нь үйл ажиллагааны зорилготой тохирохгүй байна. Жендэрийн салбар хорооны гишүүдийг чадваржуулах ажилд төрийн албан хаагчид, иргэдийг оролцуулсан үйл ажиллагаа тайлагнасан</i>
Биелэлт 100%	

Дээрх уулзалт, лекц сургалт нь төлөвлөгдсөн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан боловч хэрэгжилтийн тайлан нь үйл ажиллагааны зорилготой тохирохгүй байгааг харуулж байна. Төлөвлөгдсөн үйл ажиллагааны зорилтот бүлэг болох сумдын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн жендэрийн ойлголт мэдлэг сул байгааг мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын дүн илтгэж байна.

Шигтгээ

Боловсон хүчнийг сургаж бэлтгэсэн зүйл байхгүй. Цөөн хоногийн ганц нэг сургалтаар боловсон хүчин бэлтгэнэ гэж байхгүй. Суманд зохион байгуулалтын нэгж зөвлөл гэж байхгүй. Уг нь бол байх хэрэгтэй. Мөн зохион байгуулалтын нэгжийг болон байгууллагын удирдлагуудыг сургаж зөв мэдлэг мэдээлэлтэй болгох хэрэгтэй. Тэгж байж хэрэгжиж буй ажил үр дүнтэй болно.

Рашаант сумын засаг дарга

- 2018-2020 онд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас жил бүр сумдын мэргэжилтнүүдэд зориулсан чадваржуулах сургалтыг 2-3 удаа зохион байгуулсан ба сэтгэл зүйн анхан шатны тогтворжуулах үйлчилгээ үзүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, кейс төлөвлөгөө гаргах зэрэг гэр бүлийн хүчирхийллийн кейст хэрхэн ажиллах талаар сургаж чадваржуулжээ. Мөн аймгийн ГХУСАЗЗ, ГБХЗХГ хамтран Хамтарсан баг-үүрэг хүлээгчдийн зөвлөгөөн зохион байгуулсан нь орон нутгийн түвшинд ажиллаж байгаа хамтарсан багийн гишүүд буюу сумдын засаг дарга, нийгмийн ажилтан, цагдаагийн хэсгийн төлөөлөгч, багийн дарга жендэрт суурилсан хүчирхийллийн талаар нэгдсэн ойлголттой болсон. 2019 онд Хүрч үйлчилье нэгдсэн арга хэмжээний хүрээнд бүх сумдын хамтарсан багуудад хүрч сургалт, зөвлөн туслах ажил зохион байгуулжээ. /Эх сурвалж Жендэрийн салбар зөвлөлийн 2018, 2019, 2020 оны тайлан/

Жендэр, жендэрийн эрх тэгш байдал гэж юу болох талаар мэдлэг олгох сургалтад хамрагдаж байгаагүй гэж ганцаарчилсан ярилцлагад оролцсон сумдын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд хариулсан бол жендэрийн ойлголт хангалтгүй гэсэн хариултыг удирдах ажилтнууд өгчээ.

Шигтгээ

“Жендэрийн эрх тэгш байдал гэж юу болох талаар сургалтад хамрагдаж байгаагүй энэ чиглэлийг мэдлэг байхгүй учир иргэдэд зориулсан сургалт мэдээлэл хийх, гарын авлага боловсруулахад хүндрэлтэй байдаг”

Сайхан сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан

- Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, сумын ЗДТГ-ын дарга, байгууллагын дарга нарт зориулсан сургалтын хөтөлбөр гаргах, шаталсан сургалтыг зохион байгуулах ажлын хүрээнд улирал бүрийн аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний үеэр сумын дарга, ИТХ-ын дарга нарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаар мөн гэр бүлийн асуудлаар мэргэжил арга зүйгээр хангаж, улирлын хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулсан ажил үйлчилгээнд хэрхэн хамрагдсан, юунд анхаарах асуудлаар чиглэл өгч санал бодлыг сонсож ажиллаж байна. /ОНЖДХ-ийн тайлан 2013-2016/ Сум, орон нутаг, албан байгууллагын дарга удирдах ажилтнуудад улирал тутам мэдээлэл өгч ажилласан гэж тайлагнасан ч жендэрийн тухай ойлголт, жендэрийн эрх тэгш байдлын талаар мэдлэгийг хангалттай өгч чадаагүй байна. Ганцаарчилсан ярилцлагад оролцсон удирдах ажилтнууд өөрсдийгөө жендэрийн талаар хангалттай мэдлэггүй гэж дүгнэсэн.

Шигтгээ

“Хариуцсан нэгж бол мэргэжилтэн байдаг. Гэхдээ сургаж чадаагүй. Мөн удирдлагууд мэдлэг мэдээлэл хомс. Хүйсийн харьцаа, эмэгтэйчүүдийн оролцооноос хэтрэхгүй”

Шигтгээ:	
Төрийн байгууллага:	ОХШҮ:
<p>Үйл ажиллагаа 1.6 Орон нутгийн бодлого, стратеги, төсөл, хөтөлбөрүүдэд жендэрийн дүн шинжилгээ, судалгаа хийх ажилд ТББ-уудыг сургаж, дадлагажуулах, шаталсан сургалтыг Үндэсний хороотой хамтран зохион байгуулах</p>	
<p>Жендэрийн асуудал мэргэжилтэн нь 2014, 2016 онуудад жендэрийн Үндэсний хороо, ХАХНХЯ-аас хамтран зохион байгуулсан “Жендэрийн бодлого төлөвлөлт үйл ажиллагаа” сэдэвт сургалт, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай үндэсний хөтөлбөрийн төсөл”-д санал авах хэлэлцүүлэгт тус тус хамрагдлаа. Биелэлт 100%</p>	<p>Хэрэгжилтийн тайлан нь үйл ажиллагааны зорилготой тохирохгүй байна. ОНЖДХ-ийн 2013-2016 оны хэрэгжилтийн тайланд ТББ-ыг жендэрийн тухай ойлголт, ЖЭТБ-ын талаарх чадваржуулах сургалтад хамруулсан талаар дурдаагүй. Харин эмэгтэйчүүдийн чуулган хийх ажлын хүрээнд 2 ИНБ-тай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулсан талаар дурдсан байна.</p>

- Жендэрийн асуудлаар орон нутгийн түвшинд хүйсээр ангилсан статистикийн мэдээ гарган аймаг, сум, байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн сангийн мэдээллийг ил тод болгон мэдээлэх, түүнийг бодлого боловсруулахад ашиглан ажиллаж байна. Мөн хуулийн хэрэгжилтийг ханган төрийн албан дахь хүйсийн тэнцвэртэй байдал, удирдах албан тушаалтны хүйсийн тэнцвэртэй байдлын талаарх дэлгэрэнгүй судалгааг гарган Жендэрийн үндэсний хороонд хүргүүлсэн байна. Мөн салбар дундын мэдээллийн санд зориулан нийгмийн салбарын хүрээнд ажилгүйдэл, эрүүл мэнд, боловсролын салбарын жендэрийн тэгш байдлын судалгааг гарган ашиглаж байна.

- Жендэрийн мэдрэмжтэй мэдээ мэдээлэл, статистикийн мэдээг төрийн байгууллагууд тогтсон цаг тухайд нь статистикийн хэлтэст хүргүүлдэг байна. Тухайлбал төрийн албан хаагчдын хүйсийн талаарх мэдээлэл, хөдөлмөрийн салбарт ажиллагсдын болон эрүүл мэнд боловсролын чиглэлээр мэдээ мэдээллийг цаг тухайд нь гарган хүргүүлж байна. Хөтөлбөр хэрэгжсэний үр дүнд хүйсээр ангилсан статистик тоон мэдээллийг төрийн алба, хөдөлмөрийн харилцаа, гэр бүлийн харилцаа, боловсрол, эрүүл мэндийн салбараар жил бүр гарган мэдээллийн сан бүрдүүлэн ажилласан байна. Жил бүр нэгдсэн удирдамжийн дагуу Булган аймгийн 16 сум, агентлаг, төрийн байгууллагуудаас жендэрийн тоон судалгааг жил бүр авч хэвшсэн бөгөөд жендэрийн салбар хороон дээр мэдээллийн сан үүсгэсэн байна.

Гэвч тоон мэдээлэл судалгааг ашиглан жендэрийн эрх тэгш байдлыг бий болгох, хүйсийн зөрүүтэй байдлыг арилгах бодлогын зохицуулалт, үйл ажиллагаа хийгдэхгүй байгаа талаар ГЯ-д оролцсон мэргэжилтнүүд дурдаж байсан.

Шигтгээ

Байгууллагаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд эрэгтэй, эмэгтэйчүүдийг тэгш оролцуулна, боловсон хүчний хүйсийн тэнцвэртэй байдлыг тэгшитгэх гэдэг бол хэцүү. Бодлогын түвшинд тэгш байлгана гэдэг зүйл алдагдсан. ИТХ-ын сонгуульд нам хүртэл нэр дэвшүүлэхдээ хүйсийн харьцааг тэгш байлгаж чадахгүй байна. Харин сонгуулийн дараа хурал дээрээ жендэрийн тэгш байдал алдагдсан байна гээд байдаг.

Хамгийн наад зах нь намын дарга өөрөө ЖТБ-ын талаар мэдлэгтэй байх хэрэгтэй. Сонгуульд гарсныхаа дараа тэгш байдал, оролцоо яриад байдаг

Булган сумын ЗДТГ-ын дарга

- 2013-2016 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дунд зонхилон тохиолдож нас барж байгаа өвчлөлтэй тэмцэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- Сумын Гэгээрэл төвийн насан туршийн тасралтгүй боловсролыг эрэгтэй, эмэгтэй тэгш хүртэх боломжоор хангах
- Хөдөлмөрийн харьцаан дах жендэрийн эрх тэгш байдлыг хангаж буйд чиглэсэн хяналт, шалгалтын ажлыг бүх шатанд зохион байгуулах зэрэг үйл ажиллагааны хэрэгжилт нь тухайн салбарын статистик тоо байх агаад энэ судалгаанд үндэслэж хэрэгжүүлсэн ажил дурдагдаагүй байна.

Шигтгээ

Судалгааны дагуу тоймтой ийм ийм ажил хийсэн гээд нэрлэхэд хүндрэлтэй. ТАХ-дын хүйсийн харьцааны судалгаа гаргаад л биелэлт явуулдаг даа

Сэлэнгэ сумын засаг дарга

- ОНЖДХ-ийн хэрэгжилтийн тайланд хяналт шинжилгээ хийх явцад үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт уялдаа холбоогүй байх тохиолдол гарч байна. Үүнээс шалтгаалан төлөвлөгдсөн үйл ажиллагааг үр дүнгүй хэрэгжсэн байна гэсэн дүгнэлээ.

Хүснэгт 13. ОНЖДХ-ийн хэрэгжилт /1.12/

Шигтгээ:	
Төрийн байгууллага:	ОХШҮ:
Үйл ажиллагаа 1.12 Жендэрийн асуудлаар сургалт явуулах аймаг, сумын сургаач багш нарыг бэлтгэх, эрх олгох	
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах талаар хөдөө орон нутгийн залуучуудад сургалт сурталчилгааны ажлыг 2 удаа зохион байгууллаа. “Гэр бүлийн үнэ цэнэ”сэдэвт 45 хоногийн аяны хүрээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлийн хэлэлцүүлэг хийж, Булган сумын нийгмийн эмзэг бүлгийн зорилтот өрхийн тэргүүний сургалт, уулзалтыг зохион явууллаа. Сумын хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай асуудлаар нийгмийн ажилтнуудыг бэлтгэн 2 удаагийн мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан	Хэрэгжилтийн тайлан нь үйл ажиллагааны зорилготой тохирохгүй байна. Тайлангийн утга агуулгаас харахад үйл ажиллагааны хэрэгжилтийг өөр үйл ажиллагааны хэрэгжилтээр нөхөх байдлаар тооцсон байна.
Биелэлт 100%	

Зорилт 2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын стратегийг сурталчлах, жендэрийн сургалт, гэгээрлийн ажлаар олон нийтэд хүйсийн тэнцвэртэй байдлын талаархи зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлэх

Энэ зорилтын хүрээнд 7 үйл ажиллагаа төлөвлөж үүнээс 5 үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 14. Зорилт 2. Хэрэгжсэн үйл ажиллагаа

ҮА-ны дугаар	Төлөвлөгдсөн үйл ажиллагаа	Хэрэгжилтийн байдал	
		2013-2016	2017-2020
2.1	Төрийн албан хаагчид, аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдад жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой хууль, тогтоомж, стратегийг сурталчлах, сургалт зохион байгуулах, зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэгийн түвшинг тогтоох	Тийм	Тийм
2.2	Жендэрийн асуудлаар иргэд, олон нийтийн мэдлэг, хандлага, ойлголтыг өөрчлөх, жендэрийн боловсролыг дээшлүүлэх нөлөөлөл, сурталчилгааны ажлыг ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлэх	Тийм	Үгүй
2.3	Орон нутгийн хэвлэл, ТВ-үүд мэдээлэл нийтлэлийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгох, жендэрийн асуудлаар бие даасан булан, тусгай нэвтрүүлэгтэй болох	Үгүй	Тийм
2.4	Олон нийтэд хуулийг сурталчлах хялбарчилсан мэдээлэл, гарын авлага бэлтгэн тараах	Тийм	Тийм
2.5	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, стратеги, аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах талаар олон нийтийн хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулах	Тийм	Тийм
2.6	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны тайлан мэдээг ТББ-уудаар хэлэлцүүлэх	Тийм	Тийм
2.7	Сэтгүүлч, сурвалжлагч нарыг жендэрийн асуудлаар мэргэшүүлэх сургалтад хамруулах	Үгүй	Үгүй

Энэ зорилтын 2.2 жендэрийн асуудлаар иргэд, олон нийтийн мэдлэг, хандлага, ойлголтыг өөрчлөх, жендэрийн боловсролыг дээшлүүлэх нөлөөлөл, сурталчилгааны ажлыг ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлэх үйл ажиллагаа нь аймгийн жендэрийн салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагаанд төлөвлөгдсөн боловч хэрэгжээгүй. 2.7 сэтгүүлч, сурвалжлагч нарыг жендэрийн асуудлаар мэргэшүүлэх сургалтад хамруулах үйл ажиллагаа нь 2017-2020 оны жилийн төлөвлөгөөнд ороогүй байна.

- Төрийн албан хаагчид, аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдад жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой хууль, тогтоомж, стратегийг сурталчлах, сургалт зохион байгуулах, зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэгийн түвшинг тогтоох үйл ажиллагаа нь баримт бичгийн дүн шинжилгээнээс харахад хангалтгүй хийсэн гэж дүгнэж байна.

Хүснэгт 15. ОНЖДХ-ийн хэрэгжилт/2.1/

Шигтгээ:	
Төрийн байгууллага:	ОХШҮ:
Үйл ажиллагаа 2.1 Төрийн албан хаагчид, аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдад жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой хууль, тогтоомж, стратегийг сурталчлах, сургалт зохион байгуулах, зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэгийн түвшинг тогтоох	

<p>Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн болон сумын нийгмийн ажилтнуудын зөвлөгөөний үеэр 2-3 удаагийн сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулж төрийн албан хаагчдад жөндөрийн талаарх мэдээллийг хүргэж ажилласан</p> <p>Биелэлт 70% /2013-2016 оны хэрэгжилтийн тайлан</p>	<p>Тусгайлсан сургалт зохион байгуулаагүй. Удирдах ажилтан, нийгмийн ажилтнуудад мэдээлэл өгч ажилласнаар хэрэгжилтийг тооцсон. Нийт төрийн албан хаагчид болон бусад байгууллагын ажиллагсдад хүрээгүй.</p>
<p>Сумдын нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтныг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчтой ажиллах арга зүйд суралцуулах, сэтгэл зүйчгүй газарт анхан шатны сэтгэл зүйн тогтворжуулах үйлчилгээ үзүүлэх чадамжтай болгох зорилготой 88 багц цагийн сургалтыг 2018, 2019 онуудад “Монгол Өрх сэтгэл зүйн хүрээлэн”-тэй хамтран зохион байгуулж давхардсан тоогоор 85 нийгмийн ажилтныг хамрууллаа.</p> <p>Үүний үр дүнд аймгийн 16 суманд сэтгэл зүйн тогтворжуулах үйлчилгээ үзүүлэх чадамж бүхий 32 нийгмийн ажилтан бэлтгэгдэж, сургалтад хамрагдсан нийгмийн ажилтнууд нь орон нутагт хүүхэд болон насан хүрээгч, хүчирхийллийн хохирогч нарт анхан шатны сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг нийт 106 үйлчлүүлэгчдэд үзүүлж ажилласан байна.</p> <p>Биелэлт 100% /2019 оны хэрэгжилтийн тайлан/</p>	<p>Төлөвлөгдсөн үйл ажиллагааны зорилготой нийцээгүй. Тайлангийн утга агуулгаас харахад үйл ажиллагааны хэрэгжилтийг өөр үйл ажиллагааны хэрэгжилтээр нөхөх байдлаар тооцсон байна.</p>

- 2013-2016 оны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Жэндэрийн асуудлаар иргэд, олон нийтийн мэдлэг, хандлага, ойлголтыг өөрчлөх, жөндөрийн боловсролыг дээшлүүлэх нөлөөлөл, сурталчилгааны ажлыг ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн ч ТББ-уудыг жөндөрийн эрх тэгш байдлын чиглэлээр чадваржуулах ажил хийгдээгүй тул олон нийтийн жөндөрийн боловсролыг дээшлүүлэх ажил хангалтгүй хийгдсэн. 2017-2020 оны хэрэгжилтийн тайланд дурдснаар төсөв санхүүжилт байхгүйгээс мэргэшсэн ТББ бэлтгэж чадаагүй байна. ТББ-аар дамжуулан жөндөрийн талаарх ойлголтыг хөдөөгийн хүн амд хүргэх, мэдээлэл сурталчилгаа хийх үйл ажиллагаа төлөвлөж суурь түвшнийг тодорхойлоогүй, хүрэх түвшинг иргэд олон нийтийн жөндөрийн мэдлэг дээшилж, жөндөрийн зөв ойлголт хандлага төлөвшинө гэж тодорхойлсон байна.

Асуулгад оролцсон иргэдийн 13 буюу 9,8% нь жөндөрийн ойлголтын талаар зөв мэдлэгтэй байгаа ба 17 буюу 12.8% нь ОНЖДХ-ийн талаар мэднэ гэж хариулсан байна. Бүлгийн ярилцлагын оролцсон иргэдийн дийлэнх нь жөндөрийн тухай ойлголтгүй, мөн орон нутгийн жөндөрийн дэд хөтөлбөрийн талаар сонсож байгаагүй гэж хариулсан нь асуулга судалгааны дүн баталгаажуулж буй хэрэг юм.



Эх сурвалж: Асуулгын үр дүнгээс

Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран хүйсийн тэнцвэртэй байдлын талаар мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд хүргэх гэсэн үйл ажиллагааны суурь түвшин хангалттай тодорхойлогдоогүй, харин хүрэх түвшинг улирал тутам мэдээлэл хүргэж байхаар тодорхойлсон байна. 2013-2016 онд хэрэгжсэн хөтөлбөрийн тайланд Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл тогтмол үйл ажиллагаа явуулдаггүй тул, нэвтрүүлэг бэлтгэх боломжгүй байсан гэж тайлагнажээ. Аймгийн жендэрийн салбар хорооны жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний 2019 оны хэрэгжилтийн тайланд орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн төлөвлөгөөний гүйцэтгэлд тусгаснаар 3 төрлийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж минутын мэдээ болон постерийг цахим орчинд сурталчилжээ. Булганы мэдээ сонин, Сайхан монгол ТВ зэрэг орон нутгийн мэдээллийн хэрэгслүүд нь мэдээллийг хэрхэн олон нийтэд түгээх талаар арга зүй дутмаг учраас олон нийтэд түгээх мэдээ, мэдээлэл хангалттай хийгдээгүй.



Эх сурвалж: Асуулгын үр дүн

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулах гэсэн үйл ажиллагааны суурь түвшин жилд 1 удаа хэлэлцүүлэг зохион байгуулдаг гэсэн суурь түвшинг тодорхойлж, хүрэх түвшинг жилд 2-оос багагүй удаа хэлэлцүүлэг, ярилцлага хийж байхаар тодорхойлсон нь тодорхой түвшинд хэрэгжсэн байна. Тухайлбал 2013-2016 оны хөтөлбөрийн Манлайлагч эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулсан. Харин эрэгтэйчүүдийн чуулга уулзалтыг хөрөнгө санхүүгийн байдлаас зохион байгуулаагүй байна.

2019 оны салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлангаас харахад жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, 500 эмэгтэйн чуулган уулзалт, төлчин эмэгтэйчүүдийн чуулган, эрэгтэйчүүдийг оролцуулсан Эрчтэй өглөө арга хэмжээ гэх мэтээр зохион байгуулагдсан байна.

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн чиглэлээр гарын авлага боловсруулан тараах үйл ажиллагааны суурь түвшин 0, хүрэх түвшинг жилд нэг удаа гарын авлага гаргаж хүргүүлсэн байх гэж тодорхойлсон. Жендэрийн тухай ойлголт, жендэрийн дэд хөтөлбөрийн тухай мэдээллээр гарын авлага бэлтгэж сум, байгууллагын удирдлагууд, ажилтнуудад хүргүүлсэн тухай жил бүрийн хэрэгжилтийн тайлан дээр тусгажээ.

Зорилт 3. Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, жендэрийн шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтыг улс төр, нийгэм эдийн засаг, хөдөлмөр, гэр бүлийн харилцаанд хориглох, түүнээс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлэх

Энэ зорилтын хүрээнд төрийн алба дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хөдөлмөрийн харилцааг жендэрийн мэдрэмжтэй болгох, гэр бүлийн харилцаа дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эрүүл мэндийн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах, боловсролын харилцаа дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах 5 дэд зорилтын хүрээнд 45 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлсэн.

Хүснэгт 16. Зорилт 3. Хэрэгжсэн үйл ажиллагаа

ҮА-ны дугаар	Төлөвлөгдсөн үйл ажиллагаа	Хэрэгжсэн эсэх	
		2013-2016	2017-2020
3.1	Төрийн байгууллага, ажил олгогчид Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг ажилтнууддаа мэдээлж байх	Тийм	Тийм
3.2	Төрийн байгууллага, ажил олгогчид бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг нээлттэй мэдээлэх	Тийм	Үгүй
3.3	Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээ, байгууллагын дотоод журамд тусгах тухай зөвлөмж гарган нэгж байгууллагуудад хүргүүлэх	Тийм	Үгүй
3.4	Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай иргэний гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх удирдамжийг хэрэгжүүлэх	Тийм	Үгүй
3.5	Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай иргэний гомдлыг шийдвэрлэх арга зүйд орон тооны бус ажилтнуудыг сургах дадлагажуулах	Тийм	Үгүй
3.6	Орон нутгийн сонгуульд оролцогчдын хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахад анхаарч ажиллах /ялангуяа эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх	Тийм	Тийм

Хүснэгт 15 харахад 3 зорилтын үйл ажиллагаануудын хэрэгжилт 2017-2020 онд хангалтгүй байна. Үүний шалтгаан нь 2017-2020 оны жил жилийн төлөвлөгөөнд 3.2, 3.4, 3.5 үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй. 2020 оны төлөвлөгөөнд 3.3 үйл ажиллагааг төлөвлөсөн ч хэрэгжүүлээгүй байна.

- 2013-2016 оны хөтөлбөрийн тайланд жендэртэй холбоотой гомдол санал ирээгүй гэж тэмдэглэгдсэн байна. 2017-2020 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланд жендэртэй холбоотой гомдол санал шийдвэрлэсэн тухай тоо баримт дурдагдаагүй байна.

Бүлгийн ярилцлагад оролцогчид 100% жендэртэй холбоотой гомдол санал хаана гаргахыг мэдэхгүй гэж хариулсан.

- Аймгийн Засаг даргын 2020 оны 02 сарын 06-ны өдрийн 01/146 тоот албан бичгээр “Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулах тухай” чиглэлийг бүх сум орон нутгийн төр, төсвийн байгууллагад хүргүүлснээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрийн байгууллагууд хөдөлмөрийн дотоод журамдаа ажлын байрны бэлгийн дарамтаас сэргийлэх, хориглох тухай заалтыг тусгаж аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсээр хянуулан баталгаажуулсан байна. /Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хорооны ажлын тайлан 2019 он/

- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн “Өглөөний цай” уулзалт арга хэмжээ, “Эмэгтэйчүүд манлайллыг түүчээлнэ” АСК тэмцээнийг эмэгтэйчүүдийн манлайлал, хамтын ажиллагааг сайжруулах, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн дунд зохион байгуулж ажилласан байна. /Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хорооны ажлын тайлан 2017, 2019 он/

Хүснэгт 17. ОНЖДХ-ийн хэрэгжилт/3.2/

<i>Шигтгээ:</i>	
<i>Төрийн байгууллага:</i>	<i>ОХШҮ:</i>
<i>Үйл ажиллагаа 3.2 Төрийн байгууллага, ажил олгогчид бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг нээлттэй мэдээлэх</i>	
<i>Төрийн байгууллагын ажлын байр, үйлчилгээнд жендэрээр ялгаварлан гадуурхах явдлаас ангид байлгахад чиглэсэн сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулж байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагууд хамтран ажиллах журмыг санаачлан аймгийн ИТХ-ын 2015 оны 134 тоот тогтоолоор батлан хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү журам нь ЭТББ-ууд төр, ТББ-тай хамтран эмэгтэйчүүдийн өмнө тулгамдаж буй аливаа асуудлыг ялангуяа ажлын байрны ялгаварлан гадуурхах асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн нөлөө үзүүлэхүйц чухал баримт бичиг боллоо. Мөн аймгийн ИТХ-дахь эмэгтэйчүүдийн Лобби бүлэг нь УИХ-ын эмэгтэйчүүдийн бүлэг, Монголын эмэгтэйчүүдийн сантай хамтран ажиллах “САНАМЖ БИЧИГ” – байгуулан жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд мониторинг хийхээр ажиллаж байна</i>	<i>Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг тодорхойгүй. Үйл ажиллагааны зорилго, хэрэгжилт уялдаа холбоогүй. Төлөвлөгдсөн үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй. Өөр үйл ажиллагааны тайлангаар хэрэгжилт тооцсон.</i>

Биелэлт 100% /2013-2016 оны хэрэгжилтийн тайлан	
---	--

Зорилт 3.1. Төрийн албан дах жендэрийн эрх тэгш байдлыг хангах

Хүснэгт 18. Зорилт 3.1 Хэрэгжсэн үйл ажиллагаа

ҮА-ны дугаар	Төлөвлөгдсөн үйл ажиллагаа	Хэрэгжилтийн байдал	
		2013-2016	2017-2020
3.1.1	Судалгаа хийж хүйсийн харьцаа алдагдсан салбаруудын мэдээллийг гаргах, нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлох	Тийм	Тийм
3.1.2	Төрийн албан хаагчдын хүйсийн төлөөллийн доод хязгаарын заалтыг хангах арга хэмжээний удирдамжийг гарган хэрэгжүүлэх	Тийм	Үгүй
3.1.3	Аймаг, сумын ИТХ, Засаг дарга, Тамгын газрын дэргэдэх хороо, зөвлөл, комисс, орон нутгийн өмчид ААНБ-ын ТУЗ зэрэг хамтын удирдлагын байгууллагын хүйсийн харьцааны судалгааг гаргах	Тийм	Тийм
3.1.4	Удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын шалгалтын агуулгад жендэрийн эрх тэгш байдлын тухай оруулах	Тийм	Үгүй
3.1.5	Хүний нөөцийн талаарх бодлогод жендэрийн асуудлыг тусган хэрэгжүүлэх	Тийм	Үгүй

- 2013-2016 оны хөтөлбөрийн тайланд төрийн албанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд зорилтын хүрээнд төлөвлөгдсөн үйл ажиллагаанууд бүгд хэрэгжсэн гэж тайланд тусгасан боловч төрийн албан хаагчдын жендэрийн судалгаанаас өөр үр дүн тодорхой үйл ажиллагаа болон оролцогчийн тоо байхгүй байна.

- Удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын шалгалтын агуулгад жендэрийн эрх тэгш байдлын тухай оруулах асуудал хангалтгүй. Энэ чиглэлээр төрийн албаны зөвлөлд хандан шалгалтын агуулгад оруулах санал тавихаар төлөвлөж байгаа талаар тайланд дурдсан байгаа нь үр дүнг тодорхой харуулаагүй байна.

- 2017-2020 оны жендэрийн салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүйсийн харьцаа харуулсан судалгаанаас өөр үйл ажиллагаанууд төлөвлөгдөөгүй байна.

- 2017-2020 онд Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагууд хамтран ажиллах журмыг санаачлан аймгийн ИТХ-ын тогтоолоор батласан. Аймгийн ИТХ-дахь эмэгтэйчүүдийн Лобби бүлэг нь УИХ-ын эмэгтэйчүүдийн бүлэг, Монголын эмэгтэйчүүдийн сантай хамтран ажиллах “САНАМЖ БИЧИГ” – байгуулан жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэнд мониторинг хийхээр ажиллаж байна гэж жендэрийн салбар хорооны 2018 оны тайланд дурдсан ч хэрэгжилт, үр дүн тайланд бичигдсэн зүйл байхгүй байна.

Шигтгээ

“Төрийн албанд ажиллаж байгаа нийт 4541 төрийн албан хаагч ажилладгаас 2877 нь буюу 63,3 нь эмэгтэй 36,6 хувь нь эрэгтэй албан хаагчид байна. Үүнээс шийдвэр гаргах түвшинд нийт 315 албан хаагч ажилладгаас 157 нь буюу 49,8 хувь нь эмэгтэй албан хаагч ажиллаж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,3 хувиар өссөн байна. Энэ нь сүүлийн үед улс төр, нийгмийн харилцаанд эмэгтэйчүүдийн идэвхи

оролцоо улам бүр нэмэгдэж, эмэгтэйчүүдийн улс төрийн мэдлэг өргөжин тэлсэнтэй холбоотой юм. Төрийн захиргааны удирдах албан тушаалтны хувьд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 42,6 хувь байгаа нь хуульд заасан хэмжээнээс 2,6 хувиар илүү байна.”
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хорооны тайлан 2019 он

Хүснэгт 19. ОНЖДХ-ийн хэрэгжилт/3.1.5/

Шигтгээ:	
Төрийн байгууллага:	ОХШҮ:
Үйл ажиллагаа 3.1.5 Хүний нөөцийн талаарх бодлогод жендэрийн асуудлыг тусган хэрэгжүүлэх	
Хүний нөөцийн талаарх бодлогод жендэрийн асуудлыг тусган хэрэгжүүлэх талаар байгууллагын дарга, эрхлэгч нар болон хүний нөөцийн ажилтнуудад чиглэл өгч ажиллаж байна. Биелэлт 70% /2013-2016 оны хэрэгжилтийн тайлан	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн тодорхойгүй. Үр шим хүртээгч, оролцогчийн мэдээлэл байхгүй.

Шигтгээ

“Төрийн албан хаагчдын жендэрийн судалгааг жил бүр гаргаж байна. Хөдөө сумдад төрийн албан хаагчдын дийлэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бид юу ч хийж чадахгүй байна. Энэ нь боловсон хүчний нөөцийн тэнцвэртэй байдлыг хангах бодлого байхгүй байгаатай холбоотой”

Рашаант сумын засаг дарга

Эндээс дүгнэхэд төрийн албанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажил 2013-2016, 2017-2020 онуудад ч адил хангалтгүй хийгдсэн байна. Үүнийг ганцаарчилсан ярилцлагад оролцсон удирдах ажилтнуудын өгсөн мэдээлэл бататгаж байна. Энэ нь жил бүр гаргаж байгаа төрийн албан хаагчдын хүйсийн судалгаанд суурилсан хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах бодлого, төлөвлөгөө байхгүй, төрийн байгууллагын удирдах ажилтнууд, төрийн алын хаагчид жендэрийн бодлого, төлөвлөлтийн талаар ойлголт, мэдлэг сул, үйл ажиллагааны төсөв байхгүй байгаатай холбоотой.

Зорилт 3.2 Хөдөлмөрийн харилцааг жендэрийн мэдрэмжтэй болгох

Хүснэгт 20. Зорилт 3.2 Хэрэгжсэн үйл ажиллагаа

ҮА-ны дугаар	Төлөвлөгдсөн үйл ажиллагаа	Хэрэгжилтийн байдал	
		2013-2016	2017-2020
3.2.1	Бага насны хүүхэдтэй эцэг эхийг дэмжих хөтөлбөртэй болгох талаар ААНБ-ын удирдлагад чиглэл өгч хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээ, дотоод журамд нь тусгуулах арга хэмжээ авах	Тийм	Тийм
3.2.2	Албан бус ажил эрхлэлтийн өнөөгийн байдалд аймгийн үзлэг хийж нэгдсэн судалгааг гаргах, хүйсийн харьцааг тогтоох, ялангуяа малчдын хөдөлмөр эрхлэлтэнд үнэлэлт дүгнэлт өгөх	Тийм	Тийм
3.2.3	Хүүхэд, ахмад настан, ХБИ-дийн асрамж зэрэг үнэлгээгүй хөдөлмөрийг үнэлэх аргачлалыг хэрэгжүүлэх	Тийм	Үгүй

3.2.4	Ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах, гомдлыг хянан шийдвэрлэх асуудлыг байгууллагын дотоод журамд тусгуулах талаар зөвлөмж гарган хүргүүлэх, дагаж мөрдөж байгааг хянан шалгах	Тийм	Тийм
3.2.5	Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний судалгаа мэдээг хүйсээр ялган гаргах	Тийм	Тийм
3.2.6	Хөдөлмөрийн харьцаан дах жендэрийн эрх тэгш байдлыг хангаж буйд чиглэсэн хяналт, шалгалтын ажлыг бүх шатанд зохион байгуулах	Тийм	Үгүй
3.2.7	Эмэгтэйчүүдийн албан ёсны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжийг судлан гэрээр буюу гэрээгээр, цагаар ажиллуулах хэлбэрийг бодлогын хувьд дэмжих	Тийм	Үгүй
3.2.8	Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгааг гаргах, өрхийн үйлдвэрлэлд эрэгтэй, эмэгтэйчүүдийг эрх тэгш оролцуулах зөвлөмж гаргах	Тийм	Үгүй

Дээрх хүснэгтээс үйл ажиллагааны хэрэгжилтийг харьцуулж харахад 2013-2016 онд хөтөлбөрийн энэ зорилтод төлөвлөсөн үйл ажиллагаа бүгд хэрэгжсэн гэж “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн хөтөлбөрийн тайлан 2013-2016”-д тайлагнасан байхад 2017-2020 онд ихэнх нь хэрэгжээгүй байна. Үүний шалтгаан нь 2017-2020 оны жилийн төлөвлөгөөнд энэ зорилтын хүрээнд цөөхөн үйл ажиллагааг төлөвлөсөн байна.

2013-2016 оны ОНЖДХ, 2017-2020 оны аймгийн жендэрийн салбар зөвлөлийн ажлын тайланд дурьдсанаар:

- Залуу эцэг эхчүүдийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор “Хүүхэд харах үйлчилгээ”-г нэвтрүүлэн 180 гаруй хүүхдийг тус үйлчилгээнд хамруулсан байна. Мөн зарим байгууллагуудад өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан ажлын байрандаа 1 өрөөг хүүхэд харах чиглэлээр тохижуулжээ.

- Залуу малчин өрхийг малжуулах арга хэмжээг 16, сум нэг тосгонд зохион байгуулж 2013-2016 онд 196 малчин өрх, 2017-2020 онд 126 малчин өрхийг хамруулан 998,8 сая төгрөгөөр 9539 толгой мал худалдан авч өгчээ.

- Ажлын байранд блэгийн дарамтаас ангид байх ажлыг 2013 оноос хойш төлөвлөж ажилласан ч байгууллагын дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх түүнийг арилгах, гомдлыг хянан шийдвэрлэх асуудлыг тусган хэрэгжүүлэх талаар аймгийн засаг даргын албан тоот 2020онд албан байгууллагуудад хүргүүлж чиглэл өгч ажилласан байна.

- Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний судалгаа мэдээг хүйсээр ялган гаргах үйл ажиллагааг жил бүр гарган мэдээллийн сан бүрдүүлсэн. Судалгааг хөдөлмөрийн насны хүн амын тоо, үүнээс эдийн засгийн идэвхтэй, эдийн засгийн идэвхгүй, ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшингээр гаргаж байна.

- Хөдөлмөрийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдал хангагдахгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна. Асуулгад оролцсон иргэдийн хамгийн олон буюу 37,6% нь жендэрийн ялгаварлан гадуурхалт хөдөлмөрийн харилцаанд байна гэж хариулсан байна. Үүний 36,8% нь ажилтан шалгаруулж авахад ялгаварлал байдаг гэж хариулсан байна. Энэ нь удирдах ажилтнуудад жендэрийн хэвшмэл ойлголт нөлөөтэй хэвээр, жендэрийн ойлголт

сул байгаа нь нөлөөлдгийг бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон иргэд болон ганцаарчилсан ярилцлагад оролцсон удирдах ажилтнуудын өгсөн мэдээллээр тайлбарлагдах юм.

Зорилт 3.3 Гэр бүлийн харилцаан дах жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар

Баримт бичгийн дүн шинжилгээ, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээс харахад жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэр бүлийн үнэ цэнэ, харилцаа, хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн үүрэг оролцоог сайжруулах чиглэлээр төлөвлөгдсөн үйл ажиллагаанууд 2013-2016, 2017-2020 оны ОНЖДХ-т жигд тусгагдан аймгийн ГБХЗХГ, ЦГ, сумдын хамтарсан багуудын оролцоотойгоор иргэд олон нийтэд хүрч сайн хэрэгжсэн байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаануудаас эрэгтэйчүүдийн чуулган зохион байгуулах ажил төсөв санхүүжилт шийдэгдээгүйн учир хэрэгжээгүй.

Гэр бүлийн өмчлөх эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийн харилцаанд жендэрийн дүн шинжилгээ хийж, тэгш байдлыг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах /3.3.1/ үйл ажиллагааны хэрэгжилт нь төмс хүнсний ногоо тариалах зоригор залуу гэр бүлүүдэд га 10 газар эзэмшүүлж, өрхийн тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлсэн талаар байгаа нь залуу гэр бүлүүдэд хамтран хөдөлмөр эрхлэх, олгох олох эхлэл тавьсан ажил болжээ.

Хүснэгт 21. Зорилт 3.3 Хэрэгжсэн үйл ажиллагаа

ҮА-ны дугаар	Төлөвлөгдсөн үйл ажиллагаа	Хэрэгжсэн эсэх	
		2013-2016	2017-2020
3.3.1	Гэр бүлийн өмчлөх эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийн харилцаанд жендэрийн дүн шинжилгээ хийж, тэгш байдлыг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах	Тийм	Тийм
3.3.2	Өрх толгойлсон олон хүүхэдтэй, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой эцэг эхчүүдийг дэмжих сум, байгууллагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Тийм	Тийм
3.3.3	Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн гэр бүлийн хөгжилд эрх тэгш оролцоход чиглэсэн нөлөөлөл, сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлэх	Тийм	Тийм
3.3.4	Гэр бүлийн хүчирхийлэл дэх хохирогчдыг хамгаалах байр, сэтгэл зүйн үйлчилгээг аймгийн төвд бий болгох	Тийм	Тийм
3.3.5	Өсвөр үе, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гэр бүлийн хөгжлийн сургагч багш нарыг бэлтгэх	Тийм	Тийм
3.3.6	Гэрлэх ёслолын ордон сумдад байгуулах	Тийм	Үгүй
3.3.7	Манлайлагч эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулах	Тийм	Тийм
3.3.9	Эрэгтэйчүүдийг жендэрийн сургалтад хамруулах	Тийм	Тийм
3.3.10	Удамшлын доголдол, оюун ухааны хомсдолоос хамгаалан “Угийн бичиг” хөтлөх бэлтгэл ажлыг хангаж, эхлүүлэх	Тийм	Тийм
3.3.11	“Гэр бүлийн хөгжилд жендэрийн тэгш байдлыг хангах нь” сэдвээр иргэд олон нийтэд мэргэшсэн лекторуудаар сургалт, лекц, уулзалт ярилцлага зохион байгуулах	Тийм	Тийм
3.3.12	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх сургалтыг зохион байгуулах, хялбарчилсан мэдээлэл, гарын авлагаар хангах	Тийм	Тийм

- Өрх толгойлсон олон хүүхэдтэй, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой эцэг эхчүүдийг дэмжих зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ дэмжицгээе”, “1 хүн 10 бууз”, “Би ч бас хайртай”, “Дулаан хувцас-Халуун сэтгэл” сэдэвт түргэвчилсэн аянуудыг аймаг, сумын хэмжээнд зохион байгуулж давхардсан тоогоор нийгмийн зорилтот бүлгийн 305 гэр бүлийн гишүүд, хүүхдүүд насанд хүрэгчдэд бууз, хичээлийн хэрэглэл, дулаан хувцас, эм тариа хүлээлгэн өгч, халуун сэтгэлийн дэмжлэг үзүүлж, өрх толгойлсон олон хүүхэдтэй, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой эцэг эхчүүдэд туслах иргэд олон нийтийн харилцаа хандлага тодорхой хувиар нэмэгдсэн байна. /Эх сурвалж: ОНЖДХ-ийн тайлан 2013-2016/ 2018-2020 онуудад Гэр бүлийн хөгжлийг дэмжих “Аз жаргалтай гэр бүл” хөгжлийн үйлчилгээг хэрэгжүүлж аймгийн хэмжээнд жил бүр зорилтот бүлгийн 300 өрхийг сонгон авч, хөгжлийн төлөвлөгөө гарган ажилласан. Энэ арга хэмжээний хүрээнд дунджаар 106 өрх сайн үйлсийн аянд хамрагдаж, дэмжлэг авсны 42 хувь нь өрх толгойлсон эмэгтэй болон эрэгтэйчүүд байлаа. /Эх сурвалж: Жендэрийн салбар хорооны тайлан 2019/

- Дэлхийн болон Монголын гэр бүлийн өдрийг тохиолдуулан ГБХЗХГ-аас “Аз жаргалтай гэр бүл” 14 хоногийн нөлөөллийн аяныг жил бүр зохион байгуулж бусдад үлгэр жишээ болсон шилдэг гэр бүлүүдийг алдаршуулах, гэр бүлийн үнэ цэнийг сурталчлах олон талын нөлөөллийн арга хэмжээг Булган аймгийн 16 сум, 1 тосгонд хэрэгжүүлж хэвшсэн байна.

- Гэр бүлийн хөгжил, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог харуулсан Хүмүүжлийн эерэг арга сургалтын сургагч багшаар ЕБС-ын сургуулийн нийгмийн ажилтан, бага ангийн багш нарыг бэлтгэн сургалтыг эцэг эх, асран хамгаалаг нарт хүргэх ажлыг зохион байгуулсан байна. Сургалтад 2013-2016 онд 665, 2017-2020 онд 8241 хүнийг хамруулсан бөгөөд Сайхан Монгол телевиз, цахим орчноор дамжуулан 7825 хүнд хүргэсэн байна. /Эх сурвалж: Жендэрийн садбар хорооны тайлан/ 2019-2020/

2016 оны аймгийн Засаг даргын А/271 дугаар захирамжаар Гэр бүл, Хүүхэд,-Залуучуудын хөгжлийн газрын дэргэд хүүхэд, эмэгтэйчүүд, гэр бүлийн гишүүдийг хүчирхийллээс хамгаалах Түр байр байгуулж, үйлчилгээний журам батлаж, үйл/ажиллагааг тогтмолжуулсан.



Эх сурвалж: ГБХЗХГ-ын үйл ажиллагааны тайлангаас

- 2019, 2020 онд жендэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд төлөвлөгдсөн олон нийтэд жендэрийн мэдлэг, ойлголт түгээх ажлын хүрээнд “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-г 2019 онд “Ойлгоё хүндэлье” гэр бүлийнхээ

төлөө”, 2020 онд Яг одоо хүчирхийллийг цэглэе” уриа доор Булган аймаг даяар зохион байгуулжээ. Энэ аяны хүрээнд жендэрт суурилсан хүчирхийллийн хор уршиг, гэр бүлийн харилцааны сөрөг хандлага, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх зорилгоор зохион байгуулсан хэлэлцүүлэг, сургалт, арга хэмжээг “Сайхан монгол” телевизтэй, Гэр бүлийн радио 106.5, Булганы мэдээ сонинтой хамтран орон нутгийн иргэдэд хүргэж ажилласан. “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” чиглэлээр видео болон постерийг цахим орчинд байршуулж сурталчлах Энэ чиглэлээр “ГОЁ ХҮН Гэр бүлийнхээ төлөө байдаг” сэдвээр мэдээ бэлдэж хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчинд түгээсэн байна. Мөн эрэгтэй албан хаагчид түлхүү ажилладаг төр төсвийн байгууллага, аж ахуй нэгжүүдэд жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, бие биеийнхээ эрхэм чанар, эрхийг хүндэтгэн харилцан ойлгох талаар хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулж 115 албан хаагчдыг хамруулсан талаар жендэрийн салбар хорооны 2019 оны тайланд дурдсан байна.

- 2020 онд “Хүүхэд хамгаалал, хүүхэд, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн нөхцөл байдал, цаашдын зорилт” уулзалтыг зохион байгуулж нийт 40 гаруй төрийн болон ТББ-ын төлөөлөл оролцож, мэдээлэл солилцон санал бодлоо ярилцлаа. энэ үйл ажиллагаа нь жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулах ажилд ИНБ-уудын татан оролцуулж дуу хоолойг нь сонсон байна. Тус уулзалтаас бүх шатны ИХТ, Засаг дарга нар болон холбогдох байгууллагуудад ЗӨВЛӨМЖ гарган хүргүүлсэн байна.

- Эмэгтэйчүүдийн дуу хоолойг сонсож, тэдний манлайлал, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2013-2016 онд “Манлайлагч эмэгтэйчүүдийн чуулган”-ыг зохион байгуулан нийт 320 гаруй эмэгтэйчүүд, 2017-2020 онд “Гэр бүлд эмэгтэйчүүдийн манлайлал” чуулганыг зохион байгуулж 500 эмэгтэйчүүдийг оролцуулсан байна. Чуулганд бүх шатны нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын удирдлага, төлөөлөгч, төр, төсвийн байгууллагуудын ерөнхий менежерээр ажиллаж байгаа эмэгтэйчүүд болон соёл, спорт, бизнесийн салбарын манлайлагч эмэгтэйчүүд оролцжээ.

- Аймгийн 16 суманд “ 100 аавуудын сургалт”-ыг Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс, Цагдаагийн газартай хамтран зохион байгуулж нийт 1600 аавуудыг хамруулсан.Мөн сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүд төрийн болон төрийн бус байгууллагуудын 1490 гаруй эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулжээ. /ОНЖДХ-ийн тайлан 2013-2016/ Булган суманд үйл ажиллагаа явуулж буй 28 албан байгууллагын эрэгтэй удирдлага, албан хаагчид “ЭРЧТЭЙ ӨГЛӨӨ” уулзалтыг зохион байгуулж нийт 80 хүн оролцож “Ойлгоё хүндэлье-гэр бүлийнхээ төлөө” уриа дор “Жендэрийн тухай ерөнхий ойлголт”, “Гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, харилцаа” сэдвээр чөлөөт ярилцлага өрнүүлсэн байна. /ЖЭТБ-ын салбар хорооны тайлан 2019/

Зорилт 3.4 Эрүүл мэндийн салбар дах жендэрийн эрх тэгш байдлыг хангах

Хүснэгт 22. Зорилт 3.4 Хэрэгжсэн үйл ажиллагаа

ҮА-ны дугаар	Төлөвлөгдсөн үйл ажиллагаа	Хэрэгжилтийн байдал	
		2013-2016	2017-2020
3.4.1	Эрүүл мэндийн салбарт судалгааг гаргаж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой хууль, тогтоомж, стратегийг сурталчлах сургалт зохион байгуулах, зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэгийн түвшинг тогтоох	Тийм	Үгүй
3.4.2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомж, стратеги, аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллах	Тийм	Үгүй

3.4.3	Эрэгтэйчүүдийн эмчийг бэлтгэх, ажиллах нөхцөл бололцоогоор хангах	Үгүй	Тийм
3.4.4	Эрэгтэйчүүдийн нас баралтад нөлөөлж байгаа хүчин зүйлийг судлах, тэдгээрийг арилгах арга хэмжээ авах	Тийм	Тийм
3.4.5	Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дунд зонхилон тохиолдож нас барж байгаа өвчлөлтэй тэмцэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Тийм	
3.4.6	Гэр бүлийн эрүүл мэндийн боловсрол хөтөлбөрийг аймаг, суманд хэрэгжүүлэх, НҮЭМ, эрүүл аж төрөх ёсны тулгамдсан асуудлаар эрэгтэй, эмэгтэйчүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг аймаг, суманд хэрэгжүүлэх	Тийм	Тийм
3.4.7	Зорилтот бүлэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх хөтөлбөрийг аймаг, суманд хэрэгжүүлэх	Тийм	Тийм

- 2013-2016 оны ОНЖДХ-ийн хэрэгжилтийн хугацаанд 7 ажил төлөвлөсний 4 үйл ажиллагаа нь зорилгын дагуу бүрэн хэрэгжсэн гэж баримт бичгийн дүн шинжилгээнд тулгуурлан дүгнэж байна.

- Эрүүл мэндийн салбарт судалгааг гаргаж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой хууль, тогтоомж, стратегийг сурталчлах сургалт зохион байгуулах ажлын хэрэгжилтийн тайланг үзэхэд жендэрийн талаар сургалт хийх бус орон нутгийн удирдлага, удирдах ажилтнуудад эрүүл мэндийн сургалт хийсэн байгаа тул зорилгын дагуу хэрэгжээгүй гэж дүгнэсэн.
- Эрэгтэйчүүдийн нарийн мэргэшлийн эмчийг бэлтгэх, ажиллах нөхцөл бололцоогоор хангах ажил нь аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан гэж тайланд дурдагдсан байгаа боловч хэрэгжилт, үр дүн гараагүй.
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дунд зонхилон тохиолдож нас барж байгаа өвчлөлтэй тэмцэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрэгтэй эмэгтэй хүмүүст зонхилон тохиолдож буй өвчлөлийн тоо мэдээ байгаа боловч, тус тоо мэдэнд тулгуурлан боловсруулсан төлөвлөгөө, хэрэгжилт тайланд дурдагдаагүй байсан тул тус тус хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэсэн.

- Эрүүл мэндийн сайдын 2014 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Эрчүүдийн эрүүл мэнд” стратегийн хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлэн “Эрчүүдээ хайрлая” уриан дор 1 сарын аяныг зохион байгуулсан. Иргэдэд халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд сургалт, сурталчилгааг хөдөлгөөнт болон суурин хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 331 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 60.927 хүн хамруулж, 5-9 төрлийн 43.710 ш гарын авлага тараасан байна. /ОНЖДХ-ийн тайлан 2013-2016/

- Зорилтот бүлэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх ажлын хүрээнд нүүдлийн амбулаторийн үзлэгээр аймгийн төвөөс алслагдсан Тэшиг сумын Хилийн 0286-р ангийн 120 гаруй албан хаагчид, 2 хилийн заставд 85 эрэгтэйчүүдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулан, хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж, цэргийн насны 1940 хүнийг нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд хамруулсан байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт “Өсвөр үеийн кабинет”-д хүүхдийн эмчийг орон тоогоор

ажиллуулж, нийт 420 хүүхдийг үзлэгт хамруулсан байна. /ОНЖДХ-ийн тайлан 2013-2016/ 2019 онд Медипас эмнэлэг, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн багш нартай хамтран эрэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг зохион байгуулан 300 гаруй эрэгтэйчүүдийг хамруулсан байгаагаас харахад эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх ажлыг 2013-2016, 2017-2020 оны ОНЖДХ хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулжээ.

- 2013-2016 онд төлөвлөсөн нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинет байгуулах ажлыг 2019 онд хэрэгжүүлж аймгийн нэгдсэн эмнэлгийн амбулаторид эрэгтэйчүүдийн кабинет байгуулан үйл ажиллагааг тогтмолжуулах, тохижуулах ажлыг зохион байгуулсан байна. 2020 онд эрэгтэйчүүдийн зонхилон тохиолдох өвчнүүд, түрүү булчирхайн хоргүй томрол, эрэгтэйчүүдийн цистит зэрэг сэдвээр нийт 9 удаагийн сургалтыг 200 гаруй иргэдэд зохион байгуулсан байна.

Зорилт 3.5 Боловсролын салбар дах жэндэрийн эрх тэгш байдлыг хангах

Хүснэгт 23. Зорилт 3.5 Хэрэгжсэн үйл ажиллагаа

ҮА-ны дугаар	Төлөвлөгдсөн үйл ажиллагаа	Хэрэгжилтийн байдал	
		2013-2016	2017-2020
3.5.1	Цэцэрлэг, сургууль, МСҮТ-ийн багш нарт жэндэрийн эрх тэгш байдалтай холбоотой хууль, тогтоомж, стратегийг сурталчлах сургалт зохион байгуулах, зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэгийн түвшинг тогтоох	Тийм	Үгүй
3.5.2	Жэндэрийн асуудлаар бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх нөлөөлөл, гэгээрэл сурталчилгааны ажлыг ТББ-аар гүйцэтгүүлэх	Тийм	Үгүй
3.5.3	Сумын Гэгээрэл төвийн насан туршийн тасралтгүй боловсролыг эрэгтэй, эмэгтэй тэгш хүртэх боломжоор хангах	Тийм	Үгүй
3.5.4	Сургалтын орчинг жэндэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгаж, жэндэрийн сургалт, гэгээрлийн үйл ажиллагааг хөтөлбөр, төлөвлөгөөтэй зохион байгуулах	Тийм	Үгүй
3.5.5	Боловсролын салбар, байгууллагын тайланд жэндэрийн эрх тэгш байдлыг хангасан ажлын үр дүнг заавал оруулан тайлагнах	Тийм	Үгүй
3.5.6	Сургууль, цэцэрлэгийн захирал эрхлэгч нарын ажлыг үнэлэх дүгнэх үзүүлэлтэд жэндэрийн эрх тэгш байдлыг хангах талаар хийсэн ажлын дүнг оруулж байх	Тийм	Үгүй

Баримт бичгийн дүн шинжилгээгээр Боловсролын салбарт жэндэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 6 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлсэн боловч тайланд дүн шинжилгээ хийхэд 5 үйл ажиллагааны үр дүн тодорхойгүй, хамрах хүрээ буюу оролцогчийн тоо байхгүй тайлагнасан байна. 2017-2019 онд боловсролын салбарт жэндэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр статистик судалгаанаас өөр ажил төлөвлөгдөөгүй. 2020 оны төлөвлөгөөнд боловсролын салбарт хийгдэх ажил төлөвлөсөн ч хэрэгжүүлээгүй. Энэ Ковид-19 цар тахлын хөл хорионоос шалтгаалсан байна. Эндээс харахад, боловсролын салбарт жэндэрийн эрх тэгш байдлын хангахад чиглэсэн үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй хэмээн дүгнэж байна.

Хүснэгт 24. ОНЖДХ-ийн хэрэгжилт/3.5/

Шуудтгээ:

Төрийн байгууллага:	ОХШҮ:
<p>Үйл ажиллагаа 3.5.1 Цэцэрлэг, сургууль, МСҮТ-ийн багш нарт жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой хууль, тогтоомж, стратегийг сурталчлах сургалт зохион байгуулах, зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэгийн түвшинг тогтоох</p>	
<p>Боловсролын салбарын нийт ажиллагсдын 1057 хүнээс 794 нь эмэгтэй буюу 75,1 хувийг эзэлж байна. Үүнээс ЕБС-ийн 555 багшийн 555 буюу 444 буюу 80.0 хувь нь эмэгтэй, цэцэрлэгийн 127 буюу 98.1 хувьтай байна. Цэцэрлэг, сургууль, МСҮТ-ийн багш нарт жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой хууль, тогтоомж, стратегийг сурталчлах сургалтыг жил бүр зохион байгууллаа. Биелэлт 90% /2013-2016 оны хэрэгжилтийн тайлан</p>	<p>Зохион байгуулсан сургалтын үр дүн тодорхойгүй. Үр шим хүртээгч, оролцогчийн мэдээлэл байхгүй. Мэдээлэл хангалтгүй</p>
<p>Үйл ажиллагаа 3.5.2 Жендэрийн асуудлаар бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх нөлөөлөл, гэгээрэл сурталчилгааны ажлыг ТББ-аар гүйцэтгүүлэх</p>	
<p>Жендэрийн асуудлаар бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, бодлого боловсруулах, шийдвэр гаргах аливаа асуудалд жендэрийн мэдрэмжтэй хандах, нөлөөлөл, сурталчлах ажлыг олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллалаа. Биелэлт 70% /2013-2016 оны хэрэгжилтийн тайлан</p>	<p>Үйл ажиллагааны мэдээлэл тодорхойгүй, оролцогчийн тоо, үр дүн байхгүй. Мэдээлэл хангалтгүй</p>
<p>Үйл ажиллагаа 3.5.4 Сургалтын орчинг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгаж, жендэрийн сургалт, гэгээрлийн үйл ажиллагааг хөтөлбөр, төлөвлөгөөтэй зохион байгуулах</p>	
<p>Иргэдэд гэр бүл, иргэн, ёс суртахуун-төлөвшил, гоо зүйн мэдрэмж, амьдрах ухааны боловсролыг нийгмийн бүх орчинд албан бус хэлбэрээр тасралтгүй эзэмшүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүллээ Биелэлт 90% /2013-2016 оны хэрэгжилтийн тайлан</p>	<p>Сургалтын хөтөлбөрийн хүртээмж, хэрэгжилт, үр дүн тодорхойгүй</p>
<p>Үйл ажиллагаа 3.5.5 Боловсролын салбар, байгууллагын тайланд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан ажлын үр дүнг заавал оруулан тайлагнах</p>	
<p>Байгууллагын тайланд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан мэдээллүүдийг бэлтгэн гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. Биелэлт 70% /2013-2016 оны хэрэгжилтийн тайлан</p>	<p>Үйл ажиллагааны мэдээлэл хангалтгүй, үр дүн байхгүй. Хэрэгжилт тооцох боломжгүй</p>

Үйл ажиллагаа 3.5.6 Сургууль, цэцэрлэгийн захирал эрхлэгч нарын ажлыг үнэлэх дүгнэх үзүүлэлтэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар хийсэн ажлын дүнг оруулж байх	
Сургууль, цэцэрлэгийн захирал эрхлэгч нарын ажлыг үнэлэх дүгнэх үзүүлэлтэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар хийсэн ажлын дүнг оруулж үр дүнгийн урамшуулал олгож байна. Биелэлт 90% /2013-2016 оны хэрэгжилтийн тайлан	Жендэрийн эрх тэгш байдлыг хэрхэн хангаж ажилласан талаар мэдээлэл байхгүй. Тайлагналт дутуу

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгэмшүүлэх, хөгжүүлэх өдөр өнжүүлэх бүлэг 2019, 2020 онд ГБХЗХГ, ХХҮГ, БСУГ хамтран ажиллуулж 12 хүүхэд тогтмол хамрагдсан байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч хөдөлмөр эрхэлж чаддаггүй эцэг эхчүүдэд ажил хөдөлмөр хийж өрхийн орлого олох боломжийг нээж өгчээ.

Зорилт 4. Жендэрийн мэдрэмжтэй төсөв зохион арга зүйг байгууллага, орон нутгийн төсвийг боловсруулах батлахад нэврүүлэх

Энэ зорилтын хүрээнд 3 үйл ажиллагаа төлөвлөсөн ч 2013-2016 онд энэ зорилот бүхэлдээ хэрэгжээгүй. Шалтгаан нь төсөв санхүү шийдэгдээгүй.

2017-2020 онд орон нутаг, байгууллагын төсвийг жендэрийн мэдрэмжтэй хийх сургалтад аймгийн ЗДТГ-ын төрийн сангийн мэргэжилтэн хамрагдсан. /Эх сурвалж: Аймгийн жендэрийн салбар зөвлөлийн 2019 оны тайлан/.

2013-2016 оны ОНЖДХ-т эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулахаар төлөвлөсөн. Хэрэгжилт нь эмэгтэйчүүдийн чуулганыг зохион байгуулсан, эрэгтэйчүүдийн чуулган төсөв шийдэгдээгүй тул хийгдээгүй.

Шигтгээ

“Тамхины тухай хууль гарсны дараа аймгийн ЗДТГ-т тамхины цэг байгуулахад төсвийг богино хугацаанд шийдвэрлэж тамхины цэгтэй болсон. Харин жирэмсэн эмэгтэй албан хаагчдад амрах өрөө тохижуулах ажил төсөв шийдэгдээгүй тул хийгдээгүй”

Аймгийн ЗДТГ-ын Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Төсвийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, зарцуулах ажил хийгдэхгүй байгаа нь ОНЖДХ-ийн хэрэгжилт болон аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагаанд харагдаж байгаа нь тайлан болон ярилцлагаас илэрхий байна.

ОХШ-ний дүгнэлт

- Жендэрийн асуудлаар статистикийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж жил бүр хүйсээр ангилсан тоо баримт багтаасан эмхэтгэл гаргаж түгээх, төрийн албан хаагч, эрүүл мэнд боловсрол, хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр нэгдсэн зохион байгуулалт, удирдамж, зааврын дагуу сум бүр гарган аймгийн хэмжээнд нэгтгэн боловсруулж хэвшсэн байна.

- ОНЖДХ-г хэрэгжүүлэхэд тусгайлан төсөв батладаггүй ч тухайн жилийн төлөвлөгөөнд орсон үйл ажиллагаанууд нь хариуцан хэрэгжүүлэх байгууллагуудын жилийн төлөвлөгөөнд тусгагдаж тухайн байгууллагуудын төсвөөр хэрэгждэг.

- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд хариуцсан нэгж /хамтарсан баг/ ажилтныг сургаж, чадваржуулах ажлыг аймгийн Цагдаагийн газар, ГБХЗХГ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл жил бүр зохион байгуулж тогтмол мэдээллээр ханган, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлдэг.

- Жендэрт суурилсан хүчирхийлэл буюу гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр “Жендэрт суурилсан 16 хоног”-ийн аяныг Булган аймгийн 16 сум, 1 тосгоны хэмжээнд олон нийтийн сүлжээ, цахим орчинд идэвхтэй өрнүүлж мэдээллийг өргөн хүрээнд түгээж ажилладаг.

- ГБХЗХГ-ын дэргэд хүчирхийллийн хохирогчдод зориулсан Түр хамгаалах байр байгуулсан нь байнгын ажиллагаатай байж бүх төрлийн хүчирхийллийн хохирогч насанд хүрэгч, хүүхдүүдэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байна.

- Аймгийн нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинет байгуулж тохижуулан, эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургах ажлыг зохион байгуулж эрэгтэйчүүдэд шаардлагатай сургалт, зөвлөгөө, эмчилгээ үйлчилгээ үзүүлж байна.

Оролцооны хяналт шинжилгээний үр дүнд дараах асуудлыг олж илрүүллээ.

- 2013-2016 оны ОНЖДХ нь 65 үйл ажиллагаа төлөвлсөн ч 19 үйл ажиллагаа/29%/ нь олон нийтэд хүрсэн буюу зорилтот бүлгийг хамруулсан үйл ажиллагаа болсон байна.

- Бодлогын шинжтэй үйл ажиллагаанууд нь зөвлөмж, чиглэл өгсөн, боловсруулж байгаа гэсэн тайлагналтай буюу үр дүн гараагүй .

- Төлөвлөсөн боловч хэрэгжээгүй үйл ажиллагаануудын ихэнх нь төсөв байхгүй шалтгаанаар хийгдээгүй.

- 2017-2020 оны жендэрийн салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө нь тухайн жилдээ хэрэгжих ажил үйлчилгээг тусгасан байдгаас бодлогын чанартай үйл ажиллагаанууд төлөвлөгөөнд ороогүй.

- 2017-2020 онд боловсролын салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлийн ажил хангалтгүй хийгдсэн.

- 2017-2020 онд ТББ, ИНБ-тай хамтран ажиллах ажил эхлүүлсэн ч хэрхэн хамтран ажилласан, үр дүн нь ямар байсан талаар бичигдсэн тайлан байхгүй байна.

3.2 ОРОЛЦООНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Оролцооны үнэлгээний хүрээнд ОНЖДХ-ийн талаар иргэдийн мэдлэг, энэ хөтөлбөр нь орон нутагт жендэрийн хувьд тулгамдаж буй асуудалд тулгуурлаж чадсан эсэх, иргэд олон нийтэд хэрхэн хүрч ажилласан байдал, иргэдийн жендэрийн талаарх ойлголт мэдлэг цаашид жендэрийн эрх тэгш байдлыг сайжруулахад ямар асуудалд анхаарч ажиллах талаар иргэд болон мэргэжилтнүүдийн санал бодлыг шинжиллээ.

3.2.1 ОНЖДХ болон жендэрийн талаар ТАХ, мэргэжилтнүүд, иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголт

ОНЖДХ-ийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ганцаарчилсан ярилцлагад оролцсон орон нутгийн удирдах ажилтнууд хангалтгүй гэж үнэлсэн. Сумдын удирдлагууд болон нийгмийн ажилтнууд аймгийн жендэрийн дэд хөтөлбөрийн талаар сайн мэдэхгүй гэж хариулсан байна. Мөн нийгмийн ажилтнууд хөтөлбөр хэрэгжснээр гарсан бодит үр дүн харагдахгүй байна гэж ярьсан нь хоорондын уялдаа байхгүйгээс хөдөө орон нутагт жендэрийн хөтөлбөрийн үйл ажиллагааг танилцуулаагүй байгааг харуулж байна. Нийгмийн ажилтнууд ОНЖДХ-ийн хүрээнд хамтарсан багийг чадваржуулах сургалт, үйл ажиллагаа, олон нийтэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөөн зохион байгуулснаас

өөрөөр иргэдэд жендэрийн мэдлэг, ойлголт өгөх ажил хийгдээгүй гэж ярьсан нь удирдлагуудын дүгнэлтийг бататгаж байна. Жендэрийн асуудал хариуцсан ажилтнууд жендэрийн чиглэлээр хийсэн үйл ажиллагаанд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн салбарт хийсэн үйл ажиллагааг дурдахгүй байгаа нь салбар хоорондын уялдаа холбоо муу байгааг харуулж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөрийн талаар мэдэх үү гэсэн асуултад бүлгийн ярилцлагад оролцсон төрийн албан хаагчид, малчид, хувийн хэвшлийн ажилтан, иргэдийн төлөөллийн тавны нэг нь, асуулгад оролцогч иргэдийн 12.8% мэднэ гэж хариулсан байна.



Эх сурвалж: Асуулга

2017-2020 онд аймгийн жендэрийн салбар зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомж, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, иргэд олон нийтийн хэвшмэл хандлага, ойлголтыг өөрчлөх, жендэрийн боловсролыг дээшлүүлэх нөлөөлөл сурталчилгааны ажлыг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүйсийн тэнцвэртэй байдлын талаар мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэх зэрэг арга хэмжээнүүд төлөвлөсөн ч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь төрийн албан хаагчид, иргэдэд хүрээгүй нь оролцооны үнэлгээний явцад харагдаж байна. Асуулгад оролцсон иргэдийн 9.8% нь жендэрийн тухай ойлголт бол эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгэм, соёлын ялгааг тусгасан ойлголт гэсэн зөв хариултыг сонгосон. Энэ хувь нь нийт хариултуудын дотор хамгийн бага хувийг эзэлсэн байна. Мөн 78.9% нь жендэрийн мэдлэг олгох сургалтад хамрагдаж байгаагүй гэж хариулжээ. Жендэрийн талаар мэдлэг олгох үйл ажиллагаанд оролцож байсан гэж хариулсан иргэдийн 57% нь төрийн албан хаагчид байна.

Хүснэгт 23. Жендэрийн тухай ойлголт /Асуулгын үр дүн/

Жендэрийн тухай ойлголт		Тоо	Хувь
	Эмэгтэйчүүдийн эрхийг хангах тухай асуудал	23	17.3
	Эрэгтэйчүүдийн эрхийг хангах тухай асуудал	1	.8
	Хүйсээс үл хамааран хүн бүрийн тэгш эрхийг хамгаалах тухай	50	37.6
	Хүйсийн харьцааг тэгшитгэх тухай асуудал	33	24.8

Эрэгтэй эмэгтэй хүний нийгэм соёлын ялгааг тусгасан ойлголт	13	9.8
Мэдэхгүй	13	9.8
Нийт	133	100.0

Шигтгээ

Гэр бүлийн хүчирхийллийн талаар бол их яригдах болсон мэдээлэл ч их өгдөг болсон байна лээ. Харин энэ жендэрийн талаар сургалтад сууж байгаагүй

Сайхан сумын иргэн


Жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажил хангалтгүй хийгдснийг асуулга, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын үр дүн харуулж байна. Сумдын нийгмийн ажилтнууд жендэрийн талаар өөрсдөө мэдлэг муутай тул иргэдэд зориулан сургалт, сурталчилгаа зохион байгуулж байгаагүй гэж ярьсан. Бүлгийн ярилцлагад оролцсон иргэд бүгд өөрсдийгөө жендэрийн талаар мэдлэггүй болон бага мэдлэгтэй гэж хариулсан. Мөн дийлэнх хэсэг нь жендэрийн мэдлэг олгох ямар нэгэн сургалт, цуглаан, хэлэлцүүлэг, арга хэмжээнд оролцож байгаагүй. Бүлгийн ярилцлагад оролцогчдын цөөн хэсэг нь гэр бүлийн хүчирхийллийн талаар сургалт, үйл ажиллагаанд оролцож байсан гэж хариулсан асуулгын судалгааны үр дүнг баталж байна.

Шигтгээ

Би өөрөө жендэрийн талаар үйл ажиллагаа зохион байгуулж сургалт хийж байгаагүй. Жендэрийн талаар нэг их сайн мэдлэгтэй биш. Сургалтад хамрагдаж байгаагүй.

Булган сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан

Жендэрийн талаар ойлголт мэдээллийг хаанаас авдаг талаарх асуултад хамрагдсан иргэдийн 77/57.1%/ нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээс, 55 /41.4%/ цахим хуудас, сошиал орчноос, 19 /14.3%/ сургалт үйл ажиллагаанд оролцож, 11 /8.3%/ найз нөхдөөсөө мэдээлэл авсан гэж хариулсан бол 19 /14.3%/ мэдээлэл огт аваагүй гэж хариулсан байна.



Эх сурвалж: Асуулгын үр дүн

Баримт бичгийн дүн шинжилгээнд ашигласан тайлангуудад дурдснаар аймгийн ГБХЗХГ, ГХУСАЗЗ, ЦГ жендэрт суурилсан хүчирхийлэлийн талаар хамтарсан багууд, сумын

нийгмийн ажилтнуудад жил бүр 2-3 удаагийн сургалт зохион байгуулж чадваржуулдаг төдийгүй тэднээр дамжуулан ард иргэдэд гэр бүлийн хүчирхийллийн талаар ойлголт мэдээллийг олгосон байна.

Шигтгээ

“Жендэрийн ойлголт гэхээсээ жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлаар сургалт үйл ажиллагаа зохион байгуулдаг. Жендэр маань уг нь их өргөн хүрээний ойлголт. Жендэрийн боловсрол олгох, жендэрийн сургалт нөлөөллийн ажил хангалтгүй хийгдэж байна”

Орхон сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан

3.2.2 ОНЖДХөтөлбөрийн хэрэгжилтийн байдал

2013-2016 оны ОНЖДХ болон 2017-2020 оны жендэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэрэгжилтийг 80-аас дээш хувийн гүйцэтгэлтэйгээр төрийн захиргааны байгууллага үнэлсэн. Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагаар хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны хэрэгжилтийн явцын талаар тодруулсан.

Хөдөө сумдын хувьд жендэрийн чиглэлээр хийж байгаа үйл ажиллагаа нь жендэрийн судалгаа гаргах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажил, жендэрийн 16 хоногийн аяны үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг тоотой хэдхэн ажил байгааг ганцаарчилсан ярилцлагад оролцсон мэргэжилтнүүд болон удирдах ажилтнуудын дийлэнх нь ярьсан. Мөн цөөн хэсэг нь нэмж эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулж ажилласан талаар ярьжээ. Хамтын ажиллагааны хувьд Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдын хамтарсан багууд сайн ажиллаж иргэдэд сургалт мэдээлэл зохион байгуулдаг талаар онцлон дурдсан байна. “Жендэрт суурилсан 16 хоног”-ийн аяныг зохион байгуулахад аймгаас нэгдсэн удирдамж чиглэл хүргүүлж сумын нийгмийн ажилтан зохион байгуулж суманд үйл ажиллагаа явуулдаг бүх төрийн байгууллагад хамтран оролцдог байна.

Шигтгээ

“Жендер бол бүх салбарт яригдах ёстой сэдэв. Гэхдээ одоогоор зөвхөн гэр бүлийн хүчирхийлэл чиглэлээр сургалт нөлөөллийн ажил хийгдэж байна. хамтарсан багийн гишүүдийг сургаж байна. Бусад сэдвийн хүрээнд бол хийгдсэн ажил байхгүй байна”.

Булган сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан

Сумын Засаг даргаас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг тусгайлан тооцож, биелэлтийг хэлэлцэж байгаагүй бөгөөд нийт үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хамтатган тайлагнадаг нь төдийлөн үр дүнтэй биш юм. Жендэрийн салбар зөвлөлийн хувьд аймгийн засаг даргын зөвлөлийн хуралд жилд 2-3 удаа, ИТХТ-ийн хуралд танилцуулдаг байна. Удирдлагуудын зүгээс төсвөө сайн тусгах, судлагаа мэдээллийн ажил сайн хийх, удирдах албан тушаалтнуудад сургалт мэдээлэл түлхүү хийх чиглэлээр зөвлөмж өгч байсан талаар салбар зөвлөлийн нарийн бичиг ярьж байна.

Жил бүр төрийн албан хаагчдын жендэрийн судалгааг Булган аймгийн бүх сумдын засаг даргын тамгын газар, төрийн байгууллагууд гарган мэдээллийн сан бүрдүүлж ажилласан. Гэвч мэдээллийн сан, судалгааг бодитоор үйл ажиллагаандаа ашиглаж чадахгүй байна.

Шигтгээ

“Сумдын хувьд төрийн албан хаагчдын хүйсийн харьцааны хувьд судалгаа гаргахаас илүү зүйл хийгдэхгүй байна.”

Сэлэнгэ сумын засаг дарга

Хөдөө сумдын ЗДТГ-ын хамтын ажиллагаа сул байгаа нь зохион байгуулалтын нэгж байгуулаагүй, засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд жилд 2-3 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлдэг, жендэрийн боловсрол олгох сургалт үйл ажиллагаа хийгээгүй зэргээр харагдаж байгаа ба ГЯ-д оролцсон сумдын удирдлага болон мэргэжилтнүүд нь ОНЖДХ-ийг мэдэхгүй гэж хариулсан нь үүнийг баталж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хүрээнд зохион байгуулагдсан аливаа сургалт уулзалтад оролцож байсан уу гэдэг асуултад асуулгад оролцогчдын 15% нь оролцож байсан. 12.8% хувь нь үйл ажиллагааны талаар сонсож байсан буюу нийт оролцогчдын гуравны нэг хувь нь зохион байгуулсан үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй байна. Бүлгийн ярилцлагад оролцогчдын дийлэнх хэсэг нь ямар нэгэн үйл ажиллагаанд оролцож байгаагүй гэж хариулсан ба цөөн хэсэг нь гэр бүлийн хүчирхийллийн талаар сургалтад оролцож байсан байна.



Эх сурвалж: Асуулга

Шигтгээ

“Сумын соёлын төвд болсон гэр бүлийн харилцаа- жендэрийн харилцаа гэдэг сургалтад оролцсон. Гэхдээ хүмүүс сургалтад оролцчихоод эргээд л хүчирхийллээ үйлдээд байдаг”

Орхон сумын иргэн

Шигтгээ

“Яг жендэрийн тэгш байдлын талаар сургалтад бол сууж байгаагүй. Эмэгтэйчүүдийн эрх хамгаалал, оролцооны чуулган, гэр бүлийн хүчирхийллийн тухай сургалтад сууж байсан”

Булган сумын иргэн

Иргэдийн жендэрийн асуудлаарх үйл ажиллагаанд оролцох идэвх сул байгаад тэдний жендэрийн хэвшмэл ойлголт хандлага нөлөөлж байгаа нь нийгмийн ажилтан, мэргэжилтнүүдийн ярианд дурдагдаж байна. Түүнчлэн иргэдэд жендэрийн боловсрол олгох ажил хангалтгүй хийгдснээс иргэдийн жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг муу, жендэрийн мэдлэг, мэдээлэлтэй байх нь тэдэнд ямар ашиг тустай талаар ойлголт сул байхад нөлөөлсөн байна.

Шигтгээ

“Суманд сургалттай гэхээр 5-7 хүн л ирдэг”

Орхон сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан

Шигтгээ

“Хөдөө малчдаар тойрч явах үедээ жендэрийн талаар ярихаар өө наадах чинь бидэнд хамааралтай зүйл биш байна гээд хүлээж авдаггүй”

Бугат сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан

- ОНЖДХ-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулахад тулгамдаж буй асуудал нь удирдах ажилтнууд ойлголт, мэдлэг муутай байдгаас дэмждэггүй, ач холбогдол өгдөггүй, салбар дундын уялдаа холбоо хангагдаагүй, зохион байгуулж байгаа ажилтан өөрөө мэдлэг хангалтгүй тул хэрхэн яаж зохион байгуулахаа мэддэггүй, иргэдийн дунд хэвшмэл хандлага нийтлэг байгаагаас жендэрийн асуудалд анхаарлаа хандуулдаггүй, оролцоо сул байдаг, төсөв хөрөнгө дутмаг, мэргэшсэн ТББ, мэргэжилтэн байхгүй байгаа зэрэг шалтгаануудыг ганцаарчилсан ярилцлагад оролцсон мэргэжилтэнүүд нэрлэж байна.

- ОНЖДХ нь иргэд болон байгууллага, аж ахуйн нэгжид тулгамдаж буй жендэрийн асуудлыг шийдвэрлэж чадаж байна уу гэсэн асуултад ганцаарчилсан ярилцлагад оролцсон удирдах ажилтнууд үгүй гэж хариулсан. Шалгаан нь ОНЖДХ нь нийгэмд нийтлэг тулгамдаж байгаа асуудал болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөртэй уялддаг бөгөөд орон нутгийн асуудалд тулгуурладаггүй гэсэн хариултыг өгчээ. Цаашид хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулахдаа орон нутгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудалд тулгуурлаж боловсруулах хэрэгтэйг нийгмийн ажилтнууд болон бүлгийн ярилцлагад оролцсон төрийн албан хаагчид хэлжээ. Энэ нь сумдын хувьд өөрийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхэд суурь болж өгөх юм.

Шигтгээ

“Аймгийн жендэрийн дэд хөтөлбөрийн зорилт арга хэмжээнүүд нь орон нутгийн иргэдэд тулгамдаж байгаа асуудалд тулгуурласан бус үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөнд уялдуулж лоозон маягаар хэрэгждэг. Энэ нь орон нутагт хөрсөн дээр буухгүй байна”

Сэлэнгэ сумын засаг дарга

Шигтгээ

“Төрийн албаны хүний нөөцийг тэнцвэртэй байлгах асуудлыг хөтөлбөрт тусгах гэвч хэрэгжих боломж үнэхээр хомс. Тэгэхээр жендэрийн дэд хөтөлбөр хөдөө сумдад байгаа

асуудлуудыг бүрэн тусгаж чадаж байна уу гэвэл үгүй. Нийгэмд нийтлэг байгаа асуудал бол угаасаа тусгагдаж байгаа”.

Рашаант сумын засаг дарга

Орон нутагт тулгамдаж байгаа жендэрийн асуудлаар бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагад оролцсон иргэд, асуумжийн судалгаанд оролцогчид дараах асуудлуудыг нэрлэж байна.

Эх сурвалж: Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээс

Бүлгийн ярилцлагад оролцсон иргэд

- Хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалт
- Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн хэвшмэл ойлголт
- Гэр бүлийн хүчирхийлэл их байна
- Иргэдийн жендэрийн талаарх мэдлэггүй байдал
- Жендэрийн уламжлалт хэвшмэл ойлголт хандлага

Ганцаарчилсан ярилцлагад оролцсон мэргэжилтэн

- Иргэдийн жендэрийн талаар мэдлэггүй байдал
- Гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэж байна
- Эрэгтэйчүүдийн нийгмийн идэвх, оролцоо сул байдал
- Ажлын байр дахь хүйсийн харьцаа тэнцвэртэй бус /Хөдөө орон нутагт/

Ганцаарчилсан ярилцлагад оролцсон удирдах ажилтан

- Төрийн албан хаагчийн хүйсийн харьцаа тэнцвэргүй байна
- Хөдөө орон нутаг дахь эрэгтэй эмэгтэйчүүдийн боловсролын түвшний зөрүү
- Хөдөө орон нутаг дахь дээд боловсролтой эрэгтэйчүүдийн хомсдол
- Иргэд жендэрийн талаар мэдлэггүй байдал

Эндээс дүгнэж үзэхэд Булган аймгийн хэмжээнд иргэдийн жендэрийн талаар зөв ойлголт мэдлэг сул, хэвшмэл ойлголт, хандлагатай байдал, гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэж байгаа, дээд боловсролтой эрэгтэйчүүд орон нутагтаа ирж ажиллахгүй байгаагаас ажлын байр ялангуяа төрийн албанд ажиллаж байгаа албан хаагчдын хүйсийн тэнцвэртэй байдал алдагдах, хөдөлмөрийн харилцаан дахь хэвшмэл үзэх хандлагаас үүдэлтэй ялгаварлал зэрэг асуудал тулгамдаж байгааг харуулж байна.

Жендэрийн асуудал хаана гарч байна вэ гэсэн асуултад асуулгад оролцогчид дараах байдлаар хариулсан байна.

Хүснэгт 26. Жендэрийн асуудал хаана их гарч байна вэ

Хариулт	Тоо	Хувь
Хөдөлмөрийн харилцаанд	50	37.6%
Боловсрол эзэмшихэд	5	3.8%
Төрийн үйлчилгээ авахад	17	12.8%
Гэр бүлд	36	27.1%
Олон нийтийн газарт	27	23.1%
Мэдэхгүй	33	24.8%

Хөдөлмөрийн харилцаанд гарч буй жендэрийн асуудлыг тодруулахад асуулгад оролцогчдын 36.8% нь ажлын байр зарлах, ажилтан сонгон шалгаруулахад, 18.8% нь албан тушаал ахихад, 10.5% нь ажил ар гэрийн тэнцвэр хангахад гэж хариулсан байна. Үүний

шалтгаан нь удирдлагууд жендэрийн мэдлэг ойлголт дутмагаас шалтгаалан жендэрийн эрх тэгш байдлын талаар асуудалд ач холбогдол өгдөггүй байдал юм. Мэргэжилтнүүд өөрөө сургагдаагүйгээс орон нутгийн иргэдэд хэрхэн мэдээлэл өгөхөө мэддэггүй гэж ганцаарчилсан ярилцлагад оролцсон мэргэжилтнүүд онцолсон байна.

ОНЖДХ хангалтгүй хэрэгжихэд нөлөөлсөн гол шалтгааныг аймаг, сумын түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтэд зориулан төсөв батлаагүй явдал гэжээ. Сумдын хувьд тусгайлан дэд хөтөлбөр хэрэгжүүлээгүй ба үндэсний хөтөлбөрийн хүрээнд цөөн хэдэн үйл ажиллагааг сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд багтаан төлөвлөж ирсэн. Эдгээр үйл ажиллагаанууд нь голдуу салбар бүрийн статистик тоон судалгаа гаргах, жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулахад чиглэсэн ажлууд байдаг байна. Тухайн жилд хийгдэх үйл ажиллагааны шаардагдах зардлыг засаг даргын нөөцөөс зарцуулдаг талаар ганцаарчилсан ярилцлагад оролцсон мэргэжилтнүүд болон орон нутгийн удирдлагууд тэмдэглэсэн. Аймгийн жендэрийн салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаанаас төсөв санхүүгийн боломжгүйгээс шалтгаалан цөөн хэдэн арга хэмжээ зориулалтын дагуу хэрэгждэг байна.

Шигтгээ

“Сумын хувьд жендэрийн хөтөлбөр, төлөвлөгөө байхгүй учир төсөв төсөвлөдөггүй. Шаардлагатай зардлыг засаг даргын нөөцөөс зарцуулдаг. Мөн хамтарсан багийн үйл ажиллагаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн санхүүжилтээс уялдуулж гаргадаг”

Бугат сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан

Шигтгээ

“Жендэрийн салбар хороонд ямар нэгэн төсөв хөрөнгө баталж өгдөггүй учраас жил бүрийн төлөвлөсөн ажлын 20-30 хувь нь хангалтгүй хэрэгждэг”

Жендэрийн салбар хорооны 2018 оны тайлангаас

Жендэрийн салбар хорооны төлөвлөгөө сумдад хүрч хэрэгжээгүй. Суманд хариуцаж хэрэгжүүлэх нэгж хангалтгүй, сумдын засаг даргын үйл ажиллагааны жил жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 40 шахам үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт багтдаг тул жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2-3 үйл ажиллагаа төлөвлөгддөг. Гэхдээ энэнд жендэр бол эмэгтэйчүүдийн асуудлыг хөнддөг гэсэн хэвшмэл ойлголтоор эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулах хандлага харагддаг байна.

Шигтгээ

“Эмэгтэйчүүдийн эрхийг хангах, оролцоог нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх сургалт мэдээллийн ажлууд төлөвлөж хэрэгжүүлдэг. Мөн жендэрийн статистик судалгаа гаргадаг”

Булган сумын ЗДТГ-ын дарга

3.2.4 ОНЖДХ-ийн үр шим хүртэгчид

Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагад оролцсон иргэдийн ярианаас ОНЖДХ-өөс үр шим хүртэгчидийг тодорхойлохыг хичээлээ.

Хөтөлбөрөөс шууд үр шим хүртсэн хүмүүс бол хөтөлбөрийн хүрээнд зохиогдсон сургалт, хэлэлцүүлэг, чуулган, арга хэмжээнд оролцогчид юм. Бүлгийн ярилцлагад оролцсон иргэдийн хувьд төрийн албан хаагчид, эмэгтэйчүүд, мөн мэдээлэлд ойр байдаг хүмүүс үр шим хүртэж байгаа болов уу гэж хариулсан.

Хамгийн чухал нь иргэдийн ярьж байгаагаар иргэд жендэрийн боловсрол хангалтгүй байгаагаас хөтөлбөрөөс хэрхэн үр шим хүртэж болохоо мэдэхгүй байгаа гэнэ. Мөн оролцогчид ОНЖДХ-ийн талаар мэдэхгүй байсан учир хөтөлбөрөөс хэн үр шим хүртэж байсан, ямар бүлэг нь үр шим хүртэж чадахгүй байгаа талаар нэрлэж чадахгүй байна. Бүлгийн ярилцлагад оролцогчдын дийлэнх нь иргэд мэдээлэлгүй учир үр шим хүртэж чаддаггүй гэж хариулсан байна.

Шигтгээ

*Мэдээлэл, сургалт муугаас болж байна. Мэдэхгүй байгаа хүмүүс л хохирно шүү дээ. Өөрийн идэвх оролцоо бас чухал байна даа. Идэвхгүй санаачилгаагүй байвал үр шимийг хэн ч хүртэхгүй шүү дээ
Булган сумын иргэн 64 настай тэтгэвэрт*

Жендэрийн хэвшмэл ойлголтын нөлөө иргэдийн дунд хүчтэй байгаагаас эрэгтэйчүүдийн хувьд жендэрийн эрх тэгш байдал хангагдахгүй байх тохиолдол гарч байгааг бүлгийн ярилцлагад оролцсон төрийн байгууллагын ажилтан дурдаж байна. Эрэгтэй хүн ийм тийм гэдэг ярианаас эхлээд л эрэгтэй хүнийг сурах, өөрийн эрүүл мэндэд анхаарах, нийгмээс адилхан халамж хүртдэг болгох тогтолцоог бий болгох хэрэгтэйг дурджээ. Жишээ нь: Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагын хохирогчид эмэгтэйчүүд байдаг гэсэн нийтлэг хандлагаар эрчүүдийг нь зөрчлийн хуулиар шийтгэх арга хэмжээ авдаг. Ийм хандлагын золиос болж хүчирхийлэлд өртсөн эрэгтэйчүүд шийтгүүлэх тохиолдол гарч байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж зөрчлийн хуулиар шийтгүүлсэн 10 эрэгтэйн 3 нь өөрөө хүчирхийлэлд өртсөн хүмүүс байна. Гэр бүлийн хүний зүгээс гарч буй авирт тэвчээр алдаад нэг хашгирах, гар далайснаар өөрөө хүчирхийлэл үйлдэгч болоод 21 хоног баривчлагдах тохиолдол цөөнгүй гарч байна.

Шигтгээ

“Зөрчил шалгаж байгаа байцаагч нарыг эрэгтэйчүүд бас хүчирхийлэлд өртдөг талаар сургах хэрэгтэй байна”

Бүлгийн ярилцлагад оролцсон ЦГ-ын мэргэжилтэн

Төрийн бодлого, хууль тогтоомж нь жендэрийн эрх тэгш байдлыг зөрчиж байгааг өгүүлэх тохиолдол байгаа нь ярилцлагад оролцогчдоос гарсан саналд илэрч байна. Энэ нь онцгой нөхцөл байдлын үед 0-12 настай хүүхэдтэй эхчүүд гэж богиносгосон цагаар, алсын зайнаас ажиллаж болох талаар заасан байдаг мөртлөө эрэгтэйчүүдийн хувьд зөвхөн өрх толгойлсон эцэг гэж заадаг. Үнэндээ эхнэртэйгээ ээлжлэн хүүхдүүдээ асрах шаардлага эрчүүдэд бас гардаг гэж өөрт тулгардаг асуудлаа төрийн байгууллагад ажилладаг эрчүүд ярьж байсан. Мөн тэтгэвэрт гарах насны ялгааг жендэрийн хувьд ялгаварлал гэж үзэх эрэгтэйчүүд байна.

Шигтгээ

“Хуулиндаа эрэгтэй хүн 60 настай тэтгэвэрт гарна, эмэгтэй хүн 55 настай гэдэг. Үнэндээ эрэгтэйчүүдийн насжилт багасаж байгаа гээд судалгаа харуулаад байхад хуулиараа ялгаварлаад 5 жил илүү ажиллуулж байна”

ОХШҮ-нд оролцсон иргэд, хариуцсан ажилтнууд ОНЖДХ-ийн талаар мэдээлэл муутай байсан тул үр шим хүртэж чадахгүй байгаа бүлэг, иргэдийг тодорхойлж чадахгүй байлаа.

3.2.4 ОНЖДХ цаашид хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага

ОНЖДХ цаашид хэрэгжих шаардлагатай юу гэсэн асуултад бүлгийн ярилцлагад оролцсон иргэд бүгд дэмжсэн хариулт өгсөн. Асуулгын судалгаанд оролцогчид 100% жендэрийн талаарх ойлголт мэдлэгээ сайжруулах шаардлагатай байна гэж хариулсан.

Дараагийн ОНЖДХ хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагад судалгаанд оролцогчдын 51,1% нь жендэрийн ойлголт мэдээллийг олон нийтэд түгээх, 40,6% нь гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, 21,8% нь ажлын байранд хүйсээс хамааралтай ялгаварлалыг таслан зогсоох, 21,1% нь жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах зэргийг нэрлэсэн байна. Бүлгийн ярилцлагад оролцсон иргэд ОНЖДХ-ийн хэрэгжилтийг сайжруулах, үр шимийг тэгш хүртээхэд мэдээ мэдээллийг сайн түгээх, ил тод байдлыг хангах, төсөв санхүүжилтыг хангалттай шийдвэрлэх хэрэгтэй гэжээ.

Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагад оролцсон иргэд ОНЖДХ-ийн цаашдын үйл ажиллагаанд дараах саналуудыг нэрлэсэн.

Ганцаарчилсан ярилцлагад оролцсон удирдах ажилтнууд:

- Ажлын талбар дээр гүйцэтгэж байгаа албан хаагчдаа үе шаттай сургах
- Нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, мэргэжилтэнд юу хийх талаар шат шатанд нь сургах
- Олон нийтэд мэдээлэл өгөх
- Төсөв батлах
- Суманд жендерийн асуудал хариуцсан салбар зөвлөл байгуулах хэрэгтэй.
- Боловсон хүчний бодлого боловсруулах

Төрийн албан хаагчид:

- Байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, байгууллага бүрийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох.
- Олон нийтэд мэдээлэл сайн хүргэх, жендэрийн мэдлэг олгох
- Хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх гээд хариуцаж ажиллах бүх түвшний албан хаагчдыг сургах
- Сургалт нөлөөллийн ажил түлхүү зохион байгуулах
- Мэргэшсэн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах,
- Хэвлэл мэдээлэл олон нийтийн байгууллагатай түлхүү хамтран ажиллах
- Байгууллага бүр дээр жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ажилтан байх
- Хөтөлбөр боловсруулахдаа орон нутгийн нөхцөл байдлаа сайн судалж хөрсөн дээр буулгах Нэгж дээр ажилаж байгаа хүмүүсээс асууж судлах
- Хөдөлмөрийн харилцааг эрх тэгш байлгах
- Жендэрийн боловсролыг хүүхдүүдэд ЕБС-с олгох
- Жендэр бол салбар дамнасан сэдэв тул салбар бүрт жендэрийн асуудлыг гаргаж ирэх

Иргэд:

- Эрэгтэйчүүдийн боловсрол нийгмийн оролцоог сайжруулах
- Боловсон хүчний хүйсийн харьцаанд анхаарах

- Гэр бүлийн хүчирхийллийг бууруулахад анхаарах
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- Иргэдэд жендэрийн мэдлэг олгох, оролцоог хангах, тулгамдаж байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн, түүний үр дүнг олон нийтэд мэдээллэх.
- Мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулах
- Олон нийтэд жендэрийн ойлголт мэдээллийг хүргэхдээ иргэдэд ойлгомжтой, энгийн үг хэллэгээр мэдээллийн олон талын эх сурвалжийг ашиглаж түгээх. Мэдээлэл авч чадахгүй байгаа бүлгийг илрүүлэн мэдээлэл түгээх арга замыг эрэлхийлэх
- Хөдөлмөрийн харилцаа дахь хэвшмэл ойлголтыг арилгах, ажлын байр, ажиллах нөхцөл нь эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш таатай байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах.
- Ажил олгогч, удирдах албан тушаалтанд энэ чиглэлийн сургалт мэдээллийг сайн өгөх

ОХШҮ-д оролцсон иргэдийн саналыг дүгнэж үзэхэд Булган аймагт жендэрийн эрх тэгш байдлын хувьд тулгамдаж буй асуудлыг судлан судалгааны үр дүнд тулгуурлан ОНЖДХ-ийг боловсруулах, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх нэгжийг албан хаагчдыг чадваржуулах, хөтөлбөрий үйл ажиллагааны төсвийг шийдвэрлэх, төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, албан хаагчдад жендэрийн мэдлэг олгох, сум бүр хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж, байгууллага бүрт жендэр хариуцсан ажилтанг томилон тухайн байгууллагын үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, иргэд олон нийтэд жендэрийн боловсрол олгох, сургалт нөлөөллийн ажил ИНБ, хэвлэл мэдээллийн байгууллагыг сургаж оролцуулахад анхаарах шаардлагатайг харуулж байна.

Дөрөв. ДҮГНЭЛТ

ОНЖДХ-т хийсэн оролцооны хяналт шинжилгээ, оролцооны үнэлгээний үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- ОНЖДХ нь 2013-2020 оны хугацаанд 8 жил хэрэгжсэн байна. ОХШҮ-нд оролцсон иргэд, удирдлагууд, мэргэжилтнүүдийн яриа, санал, дүгнэлтийг үндэслэн ОНЖДХ-ийн хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэгдэж байна.
- ОНЖДХ-ийг хэрэгжүүлэх салбар нэгж сумдад байгуулаагүй тул хөдөө орон нутагт хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа хийгдээгүй,
- Салбар хорооны гишүүд болон асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сумдын болон байгууллагуудын удирдах ажилтнуудыг чадваржуулах, мэдлэг олгох ажил хангалтгүй,
- ОНЖДХ-ийн хэрэгжилтийн тайлан болон жендэрийн салбар хорооны үйл ажиллагааны тайланд зарцуулсан төсөв мөнгийг дурдахгүй байгаа нь хэрэгжилтийн ил тод байдлыг хангахгүй байна,
- Иргэдэд жендэрийн боловсрол олгох ажил хангалттай хийгдэхгүй байгаагаас иргэд хөтөлбөрөөс үр шим хүртэж чадахгүй байна.
- 2017-2020 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хөтөлбөр шинээр боловсруулаагүй. Харин жил жилд нь үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна. Төлөвлөгөөнүүд нь тухайн жилийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан нь аймгийн хэмжээнд жендэрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлогын зорилт агуулаагүй байна.
- ОНЖДХ-т тусгагдсан хүйсээр ангилсан мэдээллийн сан бий болгох, Түр хамгаалах байр байгуулах, эрэгтэйчүүдийн үзлэгийн кабинет бий болгох, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах зэрэг үйл ажиллагаанууд нь бодиттой үр дүнд хүрсэн байна.
- Жендэрт суурилсан статистик тоон мэдээллийн сан бүрдүүлж ажилласан нь амжилттай боловч мэдээллийн сан ашиглалт байхгүй, судалгаанд үндэслэж хийсэн үйл ажиллагаа байхгүй,
- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, сумууд, төрийн байгууллагуудыг хамруулан зохион байгуулснаар нөлөөллийн ажлыг далайцтай зохион байгуулж олон нийтэд хүрч чаддагийг харуулсан сайн үйл ажиллагаа болсон.
- ОНЖДХ-ийг боловсруулахдаа орон нутагт тулгамдаж буй асуудалд суурилаагүйгээс асуудлыг шийдвэрлэж чадахгүй байна..
- ОНЖДХ-ийн төсөв хангалтгүй байснаас төлөвлөгдсөн үйл ажиллагаанууд зорилтот үр дүндээ хүрэхгүй,
- ОНЖДХ-ийн хэрэгжилтэд салбар хоорондын уялдаа хангагдаагүй
- ТББ, ИНБ-уудыг чадваржуулаагүй, тэдний оролцоог хангаагүй.
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг жендэрийн талаар сургаагүйгээс Орон нутгийн ОНМХ-ээр нөлөөллийн ажил хангалтгүй хийгдсэн

Тав. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн ОХШҮ-ний үр дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжүүдийг санал болгож байгаа. Үүнд:

- ОНЖДХ боловсруулахдаа орон нутгийн онцлог, тулгамдаж буй асуудлыг судлан боловсруулах
- ОНЖДХ хэрэгжүүлэх нэгжийг сум бүрд зохион байгуулж, нэгжийн боловсон хүчнийг сургаж чадавхжуулах ажлыг тогтмол зохион байгуулах, тайлан мэдээнд тусгах
- Нийгмийн салбарын байгууллагуудад жендэрийн асуудал хариуцсан ажилтныг бий болгож салбар бүрийн үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй болгоход анхаарах
- ОНЖДХ-ийн хэрэгжилтэд шаардлагатай төсөв, санхүүжилтыг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах
- Ил тод байдлыг хангаж, хөтөлбөрийн төсвийн зарцуулалтыг тайланд тусгаж байх
- Төрийн албан хаагчийн хүйсийн тэнцвэртэй байдлыг /ялангуяа хөдөө орон нутагт/ хангах чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлэх
- Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хүрээнд бий болсон судалгааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, тоон мэдээллийг ашиглах, бодлого боловсруулах
- Жендэрийн тухай ойлголтыг сурталчлах агуулга, хөтөлбөрийг мэргэжилтэн, төрийн албан хаагчид, иргэд-олон нийт гэсэн түвшний ялгаатай боловсруулж, холбогдох арга хэмжээг тогтмолжуулах,
- Мэдээлэл сурталчилгааг хэрэглэгчдийн онцлог, эрх ашиг, нөхцөл байдалтай уялдуулсан хэлбэр, агуулга, арга замаар зохион байгуулах
- Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого чиглэл, түүний үр нөлөөг орон нутагт хэрэгжүүлж байгаа бусад бодлого хөтөлбөртэй уялдуулах арга аргачлалыг нэвтрүүлэх
- Гэр бүлийн орчинд жендэрийн ойлголт, хандлагын нөлөө хэрхэн бууж байгаад дүгнэлт хийж, гэр бүлийн гишүүдийн боловсрол, төлөвшилд ойлгуулах арга замыг төлөвлөж хэрэгжүүлэх
- ТББ-уудыг жендэрийн талаар мэргэшүүлж хамтран ажиллах
- Хөдөлмөрийн харилцаа дахь хэвшмэл ойлголтыг арилгах, ажлын байр, ажиллах нөхцөл нь эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш таатай байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах.
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, жендэрийн мэдрэмжтэй нэвтрүүлэг, мэдээ бэлтгэхэд чадваржуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нөлөөлөл, сурталчилгааны ажил зохион байгуулах

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Булган аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр 2013-2016
2. Булган аймгийн Жендэрийн салбар хорооны төлөвлөгөө 2017, 2018, 2019, 2020
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хэрэгжилт 2013-2016
4. Булган аймгийн Жендэрийн салбар хорооны үйл ажиллагааны тайлан 2018, 2019
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2020
6. Жендэрийн салбар хорооны статистик мэдээ 2020
7. Булган аймгийн ГБХЗХГ-ын тайлан 2018, 2019, 2020
8. Монгол улсын Хүний эрхийн үндэсний комиссоос Булган аймгийн ЗД-д ирүүлсэн зөвлөмж
9. Булган аймгийн ИТХ, ИТХТ-ийн тогтоолын эмхэтгэл 2013, 2016 он

Ганцаарчилсан ярилцлагын удирдамж
Сум орон нутгийн удирдлага

Аймаг, сумын нэр
Байгууллагын нэр
Албан тушаал, туршлага
Эхэлсэн цаг, дууссан цаг, хаана
Ярилцагч, тэмдэглэл хөтлөгчийн нэр	

Үндсэн хэсэг**1. ОНЖДХ-ийг суманд хариуцаж ажиллаж байсан нэгж, зохион байгуулалтын талаар ярилцая**

- ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд та ямар үүрэг, хариуцлага хүлээн оролцсон бэ?
- Танай суманд Жендэрийн хувьд анхаарах асуудал байгаа юу?
- ЖЭТБХ дэд хөтөлбөр эдгээр асуудлыг шийдвэрлэхээр бүрэн тусгаж чадсан уу?
- Хөтөлбөрт туссан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор дүрэм, журам баталсан, зохицуулалт хийсэн зүйл бий юу?
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэлтэд хэдийн хэмжээний төсөв баталсан бэ? Үйл ажиллагааны төсөв, санхүүжилтэд орон нутгийн удирдлага хэрхэн анхаарч байсан бэ?
- Зохион байгуулалтын нэгжийн албан хаагчдыг Жендэр, ЖЭТБ-ын чиглэлээр яаж чадваржуулсан бэ?

2. ОНЖДХ-ийн хэрэгжилтийн талаар ярилцъя

- Хөтөлбөрийн хүрээнд ямар ямар ажлуудыг хэрэгжүүлсэн бэ?
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан мэдээллийг орон нутгийн удирдлагад хэрхэн хүргэж байсан бэ?
- Зөвлөгөө зөвлөмж өгч, хэрэгжилтийг сайжруулах талаар удирдлагууд ямар шийдвэр, зохицуулалт хийж байсан бэ?

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, цаашдын төлөвлөгөөний талаар ярилцъя

- ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилт танай суманд ямар түвшинд байна вэ?
- Энэ хөтөлбөрийг дахин хэрэгжүүлэх шаардлага байгаа юу? Хэрэв тийм бол дараагийн хөтөлбөрт юуг илүү анхаарах хэрэгтэй вэ?

Тэмдэглэл (ярилцлагын явц, ярилцагчийн ишлэл, анхаарал татахуйц яриаг онцлон тэмдэглэнэ)

ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА**Ганцаарчилсан ярилцлагын удирдамж
Жендэрийн асуудал хариуцсан сумын мэргэжилтэн**

Аймаг, сумын нэр
Байгууллагын нэр
Албан тушаал, туршлага
Эхэлсэн цаг, дууссан цаг, хаана
Ярилцагч, тэмдэглэл хөтлөгчийн нэр	

Үндсэн хэсэг

- Та аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд ямар үүрэг хүлээж ажилладаг вэ?
 -
 -
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангаж ажиллахад хэр зэрэг бэлтгэгдсэн бэ?
- Аймгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд ямар албан тушаалтан, ямар, ямар байгууллагуудтай хамтарч ажиллаж байна?

1. ОНЖДХ-ийн бүтэц нэгж, зохион байгуулалт

- Танай суманд ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцсан зөвлөл, салбар хороо, ажлын хэсэг байгуулагдсан уу? Эсвэл мэргэжилтэн хариуцаж ажилласан уу?, тийм бол ямар албан тушаалтан хариуцдаг вэ?, ажлын байрны тодорхойлолтод жендэрийн асуудлаарх эрх үүрэг туссан уу?
- Танай суманд жендэрийн хувьд анхаарах ямар асуудал байна уу?
- Танай сум ЖЭТБХ дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө баталсан уу?
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд хэдийн хэмжээний төсөв баталсан бэ? Өөр санхүүжилтийн эх сурвалж байсан уу?
- Зохион байгуулалтын нэгжийн албан хаагчид жендэр, ЖЭТБ-ын сургалтад хамрагдсан уу?
 - Жендэр, ЖЭТБ мэдлэг ойлголт
 - Бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх
 - Хүйсээс хамаарсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт
 - Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт
 - Бусад

2. ОНЖДХ-ийн хэрэгжилт

- Хөтөлбөрт туссан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд ямар ямар үйл ажиллагаа хэрэгжүүлээд байна.
 - Жишээ нь ямар шийдвэр гаргаж энэ нь хөтөлбөрийн хэрэгжилтэд ямар үр нөлөө үзүүлж байна?
 - Хөтөлбөрт хөдөлмөрийн харилцаа, эрүүл мэнд, боловсролын орчинд хүйсээс хамаарсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг арилгах, энэ чиглэлээр албан хаагчдыг сургах, гэгээрлийн үйл ажиллагааг төлөвлөн

хэрэгжүүлэхээр туссан. Энэ хүрээнд ямар, ямар үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаагаас дурдана уу?

- ОНЖДХ-ийн хэрэгжилтэд талуудын \иргэд, төрийн албан хаагч, ажил олгогч, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага\ оролцоог ямар хэлбэрээр оролцуулж, хамтарч ажилладаг вэ, хэрэгжилтийн явц, үр дүнг ажилтнууддаа мэдээлдэг үү?
- Хөтөлбөр олон нийтэд жөндөрийн ойлголт, мэдлэгийг хэрхэн хүргэж ажилласан бэ?
- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр шим юу байна? Амжилттай сайн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, сайн туршлага
- Орон нутгийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлд ЖЭТБ-ыг хангах асуудал туссан уу?
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч байсан гол бэрхшээл юу байсан бэ? Шийдвэрлэж чадсан уу? Яаж?

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, цаашдын төлөвлөгөө

- Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан Засаг даргын зөвлөл болон ИТХ-ын тэргүүлэгчдэд танилцуулж зөвлөмж дүгнэлт авсан уу?
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд ХШҮ хийсэн үү,. Хэрэгжилт ямар түвшинд байна вэ?
- Дараагийн хөтөлбөрт юуг илүү анхаарах хэрэгтэй вэ?

Жөндөрийн асуудал хариуцсан мэргэжилтнээс нэмэлтээр асуух асуулт:

- Хүйсээр ангилсан, статистикийн мэдээлэл бүрдүүлэх
- Жөндөрийн мэдээллийн санг бүрдүүлэх, бодлого боловсруулах ашиглах
- Бэлгийн дарамтаас ангид байх төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх,
- Хөтөлбөр, төлөвлөгөө, тайлагнал

Тэмдэглэл (ярилцлагын явц, ярилцагчийн ишлэл, анхаарал татахуйц яриаг онцлон тэмдэглэнэ)

БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА

Зорилго: Орон нутгийн иргэдийн Жендэрийн талаарх мэдлэг, ОНЖДХ-ийн хүртээмж, иргэдэд тулгамдаж байгаа өнөөгийн асуудал, үр шим хүртэж чадахгүй байгаа бүлгийг тодорхойлох, .

Бүлгийн ярилцлагын удирдамж					
Аймаг нийслэл, сум дүүргийн нэр				
Ярилцлага эхэлсэн, дууссан цаг, хаана				
Бүлгийн ярилцлагад оролцогчдын категори					
Чиглүүлэгчийн нэр				
Ажиглагчийн нэр				
Танилцуулга Бүлгийн ярилцлагад оролцогчдын мэдээлэл: Нийгмийн халамж үйлчилгээнд хамрагддаг иргэд					
N	Нэр	Нас	Хүйс	Эрхэлдэг ажил	Ажилласан жил
1
2
3					
4					
5					
6					
7					
8					
Үндсэн хэсэг					
1. Жендэрийн талаарх та бүхний мэдлэг ойлголт ямар байна вэ?					
2. Орон нутгийн иргэдийн жендэрийн талаарх мэдлэг ямар байгаа бол?					
3. Энэ талаарх мэдлэгээ нэмэгдүүлэх, мэдээлэл авах хэрэгцээ та бүхэнд байгаа юу?					
4. Та бүхэн ОНЖДХ-ийн талаар юу мэдэх вэ? Хөтөлбөрийн талаар сонссон зүйл байна уу? Мэдээллийг хаанаас олж авсан бэ?					
5. Жендэр, гэр бүлийн хүчирхийлэл болон ажлын байран дахь хүйсээс хамааралтай дарамт, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх, хамгаалал, хөгжил, оролцооны талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ямар нэгэн сургалт, цуглаан, хэлэлцүүлэг арга хэмжээнд та оролцож байсан уу. Энэ талаараа дэлгэрэнгүй ярьж өгөөч.					
6. Орон нутагт гэр бүл, нийгэм, хөдөлмөрийн харилцаанд эрэгтэй эмэгтэй хүмүүст тулгамдаж байгаа асуудал юу байна вэ?					
7. Энэ асуудал бэрхшээл нь төв суурин газар, хөдөө амьдарч буй иргэд малчид, хувийн хэвшилд ажиллаж буй хүмүүс, төрийн албан хаагчид, бүх насныхан, өрх толгойлсон ганц бие эцэг эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ялгаатай байна уу?					
8. Иргэд жендэртэй холбоотой гомдол саналаа хаана гаргах аа мэддэг үү? Асуудал шийдэж байсан тохиолдлыг та бүхэн сонсож байсан уу?					

9. Орон нутагт хэрэгжиж буй хөгжлийн бодлого, үйл ажиллагааны бодлого төсөл хөтөлбөр /нийгмийн халамжийн бодлого, ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр, малчдыг дэмжих хөтөлбөр гэх мэт/-ийн үр шимийг хүртэж чадаж байна уу?
10. Хэн үр шим хүртэж чадахгүй орхигдож байна вэ? Шалтгаан нь юу байна?
11. Цаашид ОНЖДХ-ийн хэрэгжилтийг сайжруулж, үр шимийг тэгш хүртэх оролцоог бий болгоход таны санал?

Төгсгөл хэсэг

1. Орон нутгийн засаг захиргаа Жендэрийн талаар хөтөлбөр хэрэгжүүлэх, арга хэмжээ зохион байгуулах шаардлага байгаа юу
2. Хэрэв байгаа бол ямар асуудалд илүү анхаарах хэрэгтэй вэ?

Тэмдэглэл (ярилцлагад оролцогчийн зан үйл, хандлагын талаарх мэдрэмж, ярилцлагын үеийн сэтгэгдэл, анхаарах асуудлыг тэмдэглэнэ)

ОРОН НУТГИЙН ЖЕНДЭРИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГА (ИРГЭД)

Сайн байна уу?

Таныг ОНЖДХ-ийн хэрэгжилтийг үнэлэх судалгаанд оролцохыг урьж байна. Судалгааны дүнг ашиглан ОНЖДХ-ийг сайжруулах зөвлөмж боловсруулах юм.

Бид судалгаанд оролцогчийг санамсаргүй байдлаар сонгосон бөгөөд таны овог нэр, гэрийн болон ажлын хаяг зэрэг хувийн мэдээллийг авахгүй болно. Таны өгсөн мэдээллийг Монгол улсын “Хувь хүний нууцын тухай” хуулийн дагуу чандлан хадгална.

1. Таны нас(бичнэ үү?)

2. Таны хүйс:

1. Эрэгтэй 2. Эмэгтэй

3. Таны боловсрол:

1. Дээд 2.Тусгай дунд 3.Бүрэн дунд
4.Бүрэн бус дунд 5.Бага

4. Таны эрхэлдэг ажил?

1. Төрийн албан хаагч
2. Хувийн хэвшлийн байгууллагын ажилтан
3. Малчин
4.Хувиараа хөдөлмөр эрхлэгч
5.Ажилгүй
6. Төрийн бус байгууллагын ажилтан
7. Тэтгэвэр, тэтгэмжид
8. Оюутан
9. Бусад.....(бичнэ үү?)

5. Таны амьдардаг газар?

1. Аймгийн төв 2. Сумын төв 3.Хөдөө

6. Жендэрийн тухай ойлголтыг та юу гэж тодорхойлох вэ? (Доорх хувилбараас зөвхөн нэг хариулт сонгоно уу?)

1. Эмэгтэйчүүдийн эрхийг хангах тухай асуудал
2. Эрэгтэйчүүдийн эрхийг хангах тухай асуудал,
3. Хүйсээс үл хамааран хүн бүрийн тэгш эрхийг хамгаалах тухай асуудал
4. Хүйсийн харьцааг тэгшитгэх тухай асуудал
5. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм соёлын ялгааг тусгасан ойлголт
6. Мэдэхгүй

7. Таны бодлоор гэр бүлд хэн нь ямар үүрэгтэй байх ёстой гэж боддог вэ?

	Аав	Ээж	Хүү	Охин
Гэр цэвэрлэх	1	2	3	4
Хоол хийх	1	2	3	4
Түлш бэлтгэх	1	2	3	4
Өрхийн орлого олох	1	2	3	4

Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх	1	2	3	4
Гэр орноо тохижуулах, засварлах	1	2	3	4
Мод, түлээ бэлтгэх	1	2	3	4
Хувцас угаах	1	2	3	4
Мал маллах	1	2	3	4
Сүү цагаан идээ боловсруулах	1	2	3	4
Өрхийн орлого олох, цалинтай ажил эрхлэх	1	2	3	4
Хурал уулзалтад оролцох	1	2	3	4

7. Та жөндөрийн тухай мэдээллийг ямар эх сурвалжаас авдаг вэ?

1. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс
2. Сошиал орчин, цахим хуудас, facebook-ээс
3. Сургалт, үйл ажиллагаанд хамрагдаж
4. Найз, нөхөд, танил талаасаа
5. Бусад..... (бичнэ үү?)
6. Мэдээлэл авч байгаагүй.

8. Та жөндөрийн мэдлэг олгох талаар ямар нэг арга хэмжээнд хамрагдсан уу?

1. Тийм
2. Үгүй

9. Хэрэв тийм бол хаанаас зохион байгуулсан вэ?

1. Орон нутгийн төрийн байгууллага (Аймгийн жөндөрийн салбар зөвлөл, Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол соёлыг газар, ГБХЗХГ, ГХУСЗ г.м)
2. Орон нутгийн иргэний нийгмийн байгууллага
3. Жөндөрийн үндэсний хороо, яамд г.м
4. Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж
5. Улаанбаатар хотын төрийн бус байгууллага
6. Бусад..... (бичнэ үү?)

10. Танай орон нутагт жөндөрийн асуудал хаана илүү гарч байна вэ?

1. Хөдөлмөрийн харилцаанд
2. Төрийн үйлчилгээ авахад
3. Гэр бүлд
4. Олон нийтийн газарт
5. Боловсрол эзэмшихэд
6. Иргэний харилцаа /Өмчийн эзэмшил/
7. Жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэхэд
8. Бусад.....(бичнэ үү?)
9. Мэдэхгүй

11. Хөдөлмөрийн харилцаанд хүйсээр ялгаварлан гадуурхах, дарамт үзүүлэх явдал бий юу? /хэдэн ч хариулт сонгож болно/

1. Ажлын байр зарлах, ажилтан сонгон шалгаруулахад
2. Мэргэжил дээшлүүлэх, хөгжихөд
3. Албан тушаал ахихад
4. Шийдвэр гаргах, удирдах албан тушаалд дэвшүүлэхэд

5. Ажлын гүйцэтгэл, цалин хөлсийг шударгаар тооцох болон шагнал, урамшуулалд тодорхойлоход
6. Ажил, ар гэрийн тэнцвэрийг хангахад
7. Хүүхэд асрах чөлөөний дараа ажилдаа орох
8. Ажлын байрны бэлгийн дарамт
9. Бусад.....(бичнэ үү?)
10. Хэлж мэдэхгүй байна

12. Булган аймгийн Жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн талаар мэдэх үү?

1. Мэднэ
2. Мэдэхгүй

13. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хүрээнд ямар нэгэн сургалт, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулагдаж байсан уу?

1. Тийм. Оролцож байсан
2. Тийм. Гэхдээ оролцоогүй
3. Зохион байгуулаагүй тул оролцоогүй
4. Хэлж мэдэхгүй байна

14. Хэрэв оролцож байсан бол та ямар сургалт, үйл ажиллагаа, арга хэмжээг нэрлэж чадах вэ? (хэдэн ч хариулт байж болно)

1. Жендэр, жендэрийн эрх тэгш байдлын талаар мэдлэг ойлголт өгөх, жендэрийн хэвшмэл хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил,
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг сурталчилах үйл ажиллагаа, сургалт
3. Орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан жендэрийн тухай ойлголт, мэдээлэл өгөх сурталчилгаа
4. Гэр бүлийн орчинд хүйсээс хамаарсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөлөл
5. Хүүхэд хамгаалал, хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх сургалт, хамтарсан байин сургалт
6. Бэлгийн дарамтаас ангид байхад чиглэсэн сургалт, хөтөлбөр, арга хэмжээ
7. Жендэрийн асуудлаарх ТББ, хэвлэл мэдээллийн байгууллагаас зохион байгуулдаг үйл ажиллагаа
8. Эмэгтэйчүүдийн чуулган, хэлэлцүүлэг
9. Бусад.....(бичнэ үү?).....

15. Аймгийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр цаашид хэрэгжүүлэхэд дараах чиглэлээр шаардлагыг хэрхэн харж байна вэ?

1. Жендэрийн ойлголт мэдлэг мэдээллийг олон нийтэд түгээх.
2. Хүйсээс хамааралтай гэр бүл, хүүхдийн хүчирхийллийг бууруулах
3. Ажлын байранд хүйсээс хамааралтай ялгаварлан гадуурхалт байгаа учраас
4. Жендэрийн хэвшмэл хандлага байсаар байна.
5. Манай орон нутагт жендэрийн асуудал байхгүй.
6. Хүн бүрд хамаатай асуудал биш тул шаардлагагүй.
7. Бусад.....(бичнэ үү?)
8. Хэлж мэдэхгүй байна.

16. Та цаашид жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн ямар нэг үйл ажиллагаанд оролцох уу?

1. Тийм
2. Үгүй

Бидний асуултад чин сэтгэлээсээ хариулсан танд баярлалаа